



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ, ҮР ДҮНД СУУРИЛСАН САНХҮҮЖИЛТИЙН
ТОГТОЛЦОО, ҮР НӨЛӨӨ

АУДИТЫН КОД:ХОА-2023/19-ШТА-ГА

Ховд хот

2023 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061

Цахим хаяг: Boldbaatar.khu@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Эрдэнэцэцэг

Утас: 70432545

Цахим хаяг: erdenetsetsegd@audit.gov.mn

Аудитор: Д.Энхжаргал

Цахим хаяг: enkhjargald@audit.gov.mn

Аудитор: Д.Балжинням

Цахим хаяг: baljinnnyamd@audit.gov.mn

Аудитор: У.Батчимэг

Цахим хаяг: Batchimegu@audit.gov.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн жагсаалт, график, схем болон хүснэгтэн мэдээллийн жагсаалт.....4

Аудитын зорилго, хамарсан хүрээ, шалгуур үзүүлэлт, стандарт, арга зүй, үндсэн мэдээлэл..

Ерөнхий мэдээлэл.....5

БҮЛЭГ 1. Хөгжлийн бодлогын баримт бичигт эрүүл мэндийн даатгалын талаар тусгасан зорилтын хэрэгжилт хангагдсан байна.

➤ Эрүүл мэндийн даатгалын үр дүнд суурилсан тусламж үйлчилгээний санхүүжилт 134.7 хувиар өссөн байна.....6

➤ Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогыг өмнөх оны орлогын гүйцэтгэлийг 2.0 дахин өсгөж үндэслэлгүй төлөвлөснөөс орлого 4.0 тэрбум төгрөгөөр тасарч авлага 226.3 сая төгрөгөөр өссөн байна.....8

БҮЛЭГ 2. Эрүүл мэндийн байгууллагаас даатгуулагчийн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцсэн зарим тусламж үйлчилгээг авч чадахгүй байна

➤ Эрүүл мэндийн даатгалын тогтолцоонд шилжсэнээр эрүүл мэндийн салбарт тодорхой ахиц дэвшил гарсан байна..... 23

➤ Эрүүл мэндийн даатгалын салбарын хяналт шалгалт, дотоод аудитын үйл ажиллагаа бүрэн хэрэгжихгүй байна.....26

АУДИТЫН ДҮН, ДҮГНЭЛТ 28

ҮАГ-т ХҮРГҮҮЛЭХ САНАЛ.....28

ЗӨВЛӨМЖ30

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН АЛБАН
ТООТ31

АУДИТ БАТАЛГААЖУУЛСАН
ТУШААЛ 33

ХАВСРАЛТУУД 34

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

Товчлол	Тайлал
АДБОУС	Аудитын дээд байгууллагын Олон Улсын стандарт
АГГ	Аудитын гуравдугаар газар
ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
ГА	Гүйцэтгэлийн аудит
ЗГ	Засгийн газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн Олон Улсын стандарт
ТУЗ	Төлөөлөн Удирдах зөвлөл
УИХ	Улсын Их Хурал
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон Улсын стандарт
ШТА	Шууд тайлагнах ажил
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
ЭМД	Эрүүл мэндийн даатгал
ЭМГ	Эрүүл мэндийн газар
НДХ	Нийгмийн даатгалын хэлтэс
БОЭТ	Бүсийн оношилгоо эмчилгээний төв
ЭМДҮЗ	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл

Хүснэгтийн товчлол

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	ЭМД-ийн төлөвлөгөө гүйцэтгэл	6
Хүснэгт 2	ЭМД-ийн санд төвлөрсөн орлогын гүйцэтгэл	8
Хүснэгт 3	Тусламж үйлчилгээний зардлын санхүүжилт	10
Хүснэгт 4	Аймгийн хэмжээний санхүүжилтийн тооцоо	11
Хүснэгт-5	БОЭТ-ийн орлого зарлагын үзүүлэлт	15
Хүснэгт-6	Сумын ЭМТ-ийн санхүүжилт	16
Хүснэгт-7	Хувийн хэвшлийн эмнэлгүүдийн үзүүлэх тусламж үйлчилгээ	17
Хүснэгт-8	Хувийн хэвшлийн эмнэлгүүдийн санхүүжилтийн тооцоо	18
Хүснэгт-9	Эмийн санд тавигдах стандарт шаардлага	19
Хүснэгт-10	Эмийн санд олгосон санхүүжилт	20
Хүснэгт-11	ЭМД-д хамрагдалтын тоон мэдээлэл	23

	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2022 оны 9 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2023 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2023 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө” -г үндэслэн хийлээ.
Аудитын зорилт	Эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагааны үр ашиг, хяналтын үр нөлөөг үнэлж дүгнэн, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдсэн болно. Аудитын зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэв. Үүнд: • Эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагааны үр дүн, төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилт хангагдсан эсэх; • Эрүүл мэндийн байгууллагаас даатгуулагчийн эрэлт, хэрэгцээ, шаардлагад нийцсэн эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эсэх;
Аудитын хамарсан хүрээ	Аудитад Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн даатгалын хэлтэс, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд, Өрхийн эмнэлгүүд, Нийгмийн даатгалын хэлтсийн 2020-2022 оны үйл ажиллагааг хамруулав.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг АДБОУБ(INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС 100, АДБОУС 300, 3000-3100-д нийцүүлсэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар “Төрийн аудит байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/69 дугаар “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ыг ашиглав. Холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга судалгаа авах, харьцуулах, нэгтгэн дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав. Аудитаар “Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө” сэдэвт аудитад хамрагдагч хуулийн этгээдийн даатгалын санхүүжилтийн эрх зүйн орчин, хуулийн этгээдийн эдийн засгийн зорилтот түвшний төлөвлөлт, хяналт, санхүүгийн үйл ажиллагаа, үр ашигт судалгаа хийх, нэгтгэсэн дүн шинжилгээ, харьцуулалт хийх, мэдээллийн ил тод нээлттэй байдал, хяналтын тогтолцооны үр нөлөө зэрэг үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналыг холбогдох баримт материалыг үндэслэн тулган баталгаажуулах, үнэлгээ хийх, асуудал хариуцсан албан тушаалтантай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах зэрэг аудитын горимыг хэрэгжүүлж ажиллаа. Манай аймгийн хувьд СТА дуусгаад орсон учир цаг хугацааны хувьд богино хугацаанд хэрэгжүүлсэн нь бэрхшээлтэй асуудал байлаа.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар удирдаж, аудитын менежер А.Цэцэгсүрэн чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Д.Эрдэнэцэцэг, аудитор Д.Балжинням, Д.Энхжаргал, У.Батчимэг нар гүйцэтгэв. Аудитыг 2023 оны 04 дугаар сарын 20-ний өдрөөс 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн хугацаанд гүйцэтгэн тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулж, УАГ-ын гүйцэтгэл, нийцлийн аудитын газар, аймгийн ЭМГ, ЭМДХ болон бусад холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүллээ

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын араа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 2021-2030 онд хэрэгжүүлэх зорилтын хүрээнд “Эрүүл мэндийн үйлчилгээнд даатгалын, улсын төсвийн болон хувь хүний санхүүжилтийн зохистой харьцааг бий болгож, хүн амын эрүүл амьдралын хэвшлийг төлөвшүүлж, иргэн бүрийг эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээнд бүрэн хамруулж, нийт сумыг хамарсан алсын зайн үндэсний сүлжээг бий болгож, хүн амын дундаж наслалт уртассан байна”, “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.1.7-д “Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн оновчтой арга, хэлбэрийг нэвтрүүлж, эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний нэр, төрлийг нэмэгдүүлж, эрсдэлийн сан байгуулна”, Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 2.1.26-д “Эрүүл мэндийн салбарт гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн аргыг нэвтрүүлж, эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийг нэмэгдүүлнэ” гэж тус тус заасан байна.

Ховд аймагт эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж эрүүл мэндийн даатгалаас санхүүжилт авдаг улсын 2, сумын ЭМТ 16, Өрхийн эмнэлэг 6, хувийн эмнэлэг 5, эмийн сан 39 нийт бүртгэлтэй 68 хуулийн этгээд үйл ажиллагаа явуулж байна.

Аймгийн хэмжээнд 2022 онд эрүүл мэндийн даатгалд их дээд сургуулийн өдрийн ангийн суралцагч 1900 хамрагдахаас 631 буюу 33.2%, малчин 6300 хамрагдахаас 3595 буюу 57.06%, ажил хөдөлмөр эрхлээгүй иргэн 5220 хамрагдахаас 4885 буюу 93.58 хувь хамрагдсан байна. Нийт 13420 иргэн хамрагдахаас 9111 иргэн хамрагдаж хамралтын хувь 67.8 хувьтай байна.

Эрүүл мэндийн даатгалын байгууллагатай гэрээ хийсэн 68 байгууллагын эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн 4500 нэхэмжлэлд хяналт хэрэгжүүлж 39.2 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна. Тухайлбал: Улсын эмнэлэгт 22.9 тэрбум, сумын ЭМТ-д 9.5 тэрбум, хувийн хэвшлийн эмнэлгүүдэд 3.0 тэрбум, Өрхийн ЭМТ-д 2.0 тэрбум, эмийн сангуудад хөнгөлөлттэй эмийн санхүүжилт 1.8 тэрбумыг тус тус олгожээ.

Тайлант онд улсын эмнэлэг 22.5 тэрбум төгрөгийн нэхэмжлэл үүссэнээс 2.8 тэрбум төгрөгийн хасалт хийсэн, хувийн хэвшлийн эмнэлгүүд 3.0 тэрбум төгрөгийн нэхэмжлэл үүссэнээс 168.9 сая төгрөгийн хасалт хийсэн, сумын эрүүл мэндийн төвүүд 1.8 тэрбум төгрөгийн нэхэмжлэл үүссэнээс 79.1 сая төгрөгийн хасалт хийсэн байна. Хасалт хийгдэж байгаа шалтгаан нь системийн хасалт 80-90%, эмч байцаагчийн хасалт 10-20%-ийг эзэлж байна.

Эрүүл мэндийн даатгалын санхүүжилт 2020 онд 8.9 тэрбум, 2021 онд 29.1 тэрбум, 2022 онд 39.2 тэрбум төгрөг буюу 134.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

ЭМДЕГ-ын даргын А/154 тоот тушаалын хүрээнд газар дээрх, хяналт шалгалтыг 5 эмнэлэгт хийж гүйцэтгэжээ. Хяналтаар 5 эмнэлгийн тоног төхөөрөмж, хүний нөөцийн мэдээллийг тулган шалгасан байна.

Эрүүл мэндийн даатгалын хэлтсээс “Эерэг хандлага-Эрүүл оюутан” аяны хүрээнд Хөгжил политехник коллежийн 150 гаруй оюутан, суралцагчид, Ховд их сургуулийн 51 оюутан, залуучуудад ЭМД-ын ач холбогдлыг таниулах сургалт зохион байгуулжээ.

БҮЛЭГ 1. Хөгжлийн бодлогын баримт бичигт эрүүл мэндийн даатгалын талаар тусгасан зорилтын хэрэгжилт хангагдсан байна.

Эрүүл мэндийн даатгалын үр дүнд суурилсан тусламж үйлчилгээний санхүүжилт 134.7 хувиар өссөн байна.

1.1 Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт эрүүл мэндийн салбарт хэрэгжүүлэх 29 хөтөлбөр арга хэмжээ батлагдсан байна.

Алсын хараа-2050 Хөгжлийн бодлогын баримт бичгийг үндэслэн Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 2.1.7¹-р заалттай уялдуулан Ховд аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 2.1.26²-д заасан зорилтыг дэвшүүлсэн байна. Зорилтын хүрээнд аймгийн хэмжээнд дараах хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 03 дугаар тогтоолын дагуу Эрүүл мэндийн даатгалын гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн аргыг Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Булган сум, сумын хөдөөгийн нэгдсэн эмнэлгүүдэд 2021 оны 3 дугаар сараас нэвтрүүлж эхэлсэн бөгөөд 2022 оноос эхлэн сум, өрхийн эрүүл мэндийн байгууллагууд гүйцэтгэлд суурилсан санхүүжилтэд бүрэн шилжсэн,
- Эрүүл мэндийн тухай хуулийн зохицуулалтын хүрээнд бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудын эмч нар олон улсын эмнэл зүйн удирдамж, ангиллын дагуу эм бичих боломжийг бүрдүүлж, бүх эмийн сан сонгон шалгаруулалтагүйгээр Эрүүл мэндийн даатгалын байгууллагатай гэрээ байгуулж, хөнгөлөлттэй эмээр үйлчлэх боломж бий болсон,
- Эрүүл мэндийн даатгалын санхүүжилт 2020 онд 8.9 тэрбум, 2021 онд 29.1 тэрбум, 2022 онд 39.2 тэрбум төгрөг буюу 134.7 хувиар өссөн байна.
- Хөгжлийн бодлогын баримт бичгийг уялдуулан Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт эрүүл мэндийн салбарт 2020-2024 онд 29 арга хэмжээ дэвшүүлсэн зорилтын хүрээнд 15682.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхээр тусгаснаас 30-80 хувийн хэрэгжилттэй байгаа нь салбарын ажилчдын ажиллах нөхцөл сайжирч, иргэдийн тав тухтай орчинд үйлчлүүлэх боломж бүрдсэн байна.

1.2 Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлөөс гаргасан тогтоол шийдвэрийг орон нутагт баримтлан ажиллаж байна.

Эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь ЭМД-ын тухай хуулийн 9-р зүйлийн 9.4³-д зааснаар Үндэсний зөвлөлөөс баталсан дараах тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэн

¹ "Нотолгоонд суурилсан орчин үеийн оношилгоо, эмчилгээний техник, технологийн дэвшлийг нэвтрүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, гүйцэтгэлд тулгуурласан санхүүжилт, даатгалын тогтолцоотой болсон байна"

² Эрүүл мэндийн салбарт гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн арга хэлбэрийг нэвтрүүлж даатгалын санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлнэ"

³ Даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээ, халдварт өвчний эсрэг дархлаажуулалтад түүний нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд үндэслэн тогтоосон товлосон хугацаанд хамруулан, эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь санхүүжүүлэх бөгөөд ХОА-2023/19/ШТА-ГА/

ажиллаж байна. ҮЗ-өөс гаргасан тогтоол шийдвэр 2021-2022 онуудад 2-3 удаа өөрчлөгдсөн байна. Тухайлбал:

- ✓ ЭМД-ын Үндэсний зөвлөлийн 2022 оны 01-р сарын 28-ны 01 дугаар тогтоол “Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай”-д заасны дагуу эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хяналт, санхүүжилт, төлбөр тооцоог хийж 2020-2022 онд 77.2 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна.
- ✓ ЭМД-ын Үндэсний зөвлөлийн 2018 оны “ журам батлах тухай” 09-р тогтоолыг шинэчлэн 2022 оны 01-р сарын 28-ны 02 тоот “журам шинэчлэн батлах тухай” тогтоолыг хэрэгжүүлэн 68 хуулийн этгээдтэй гэрээ байгуулсан байна.
- ✓ ЭМД-ын Үндэсний зөвлөлийн 2019 оны “ төлбөрийн жагсаалт, журам батлах тухай” 23, 2020 оны 14, 2021 оны 04-р тогтоолыг шинэчлэн 2022 оны 03-р сарын 23-ны 05 тоот “төлбөрийн жагсаалт, төлбөрийн арга журам шинэчлэн батлах тухай” тогтоолыг хэрэгжүүлэн давхардсан тоогоор Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 4257.6 сая төгрөг, Сумын эрүүл мэндийн төвүүдэд 12220.6 сая төгрөгийн иргэний төлбөрийг даатгалаас санхүүжүүлсэн байна.
- ✓ ЭМД-ын Үндэсний зөвлөлийн 2018 оны “журам батлах тухай” 19, 2020 оны 01-р тогтоолыг шинэчлэн 2022 оны 04-р сарын 05-ны 06 тоот “багц төлбөрийн хэмжээ журам шинэчлэн батлах тухай” тогтоолыг хэрэгжүүлэн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо шинжилгээнд иргэн хамрагдаж 522.2 санхүүжилт олгосон байна.
- ✓ ЭМД-ын Үндэсний зөвлөлийн 2019 оны “хөнгөлөлтэй эмийн журам батлах тухай” 18, 2020 оны 09, 2020 оны 13-р тогтоолыг шинэчлэн 2022 оны 07-р сарын 04-ны 11 тоот “эмийн жагсаалт, журам шинэчлэн батлах тухай” тогтоолыг хэрэгжүүлэн 45 эмийн санд 3976.1 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.
- ✓ ЭМД-ын Үндэсний зөвлөлийн 2022 оны 07 тоот “журам батлах тухай” тогтоолыг шинэчлэн 2022 оны 08-р сарын 11-ны 12 тоот “чанар, төлбөрийн хяналтын журам” тогтоолыг хэрэгжүүлэн 68 хуулийн этгээдийн нэхэмжлэлд цахимаар хяналт хэрэгжүүлсэн байна.

1.3 Эрүүл мэндийн даатгалын үр дүнд суурилсан санхүүжилт үр дүнтэй хэрэгжиж эхэлсэн байна.

Эрүүл мэндийн даатгалын цахим системийг бүрэн нэвтрүүлж эмийн сан, эрүүл мэндийн байгууллагууд, төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагуудыг эрүүл мэндийн даатгалын цахим системд холбох ажлыг бүрэн хамруулан амжилттай хэрэгжүүлсэн байна.

Олон улсад байгаа нөөцийг үр ашигтай удирдах, нэн шаардлагатай тусламж, үйлчилгээнд үр дүнтэй хуваарилах, шаардлагагүй зардлыг хумих, тусламж, үйлчилгээ үзүүлэгч болон худалдан авагчийг салгах, худалдан авагч байгууллагын худалдан авах тусламж, үйлчилгээний тэргүүлэх чиглэлийг тогтоох, ЭМБ-ыг сонгон шалгаруулах, гэрээлэх, тусламж, үйлчилгээний чанарыг үнэлэх чадавх, цахим систем, цахим хяналтыг сайжруулах нь чухал гэж үзэн үйл ажиллагаагаа чиглүүлж ажилласан байна.

Эрүүл мэндийн даатгалын байгууллага орон нутгийн статистик үзүүлэлтийг үндэслэн, мэдээллийн санг бүрдүүлэх, сангийн зардлын гүйцэтгэлийг хууль тогтоомж, тушаал журам, шийдвэрт нийцүүлэн бүрэн зөв тооцон олгох, эрүүл мэндийн даатгалын байгууллага, эрүүл мэндийн байгууллага хооронд хийсэн гэрээний хэрэгжилт, үр дүнг тооцож, даатгуулагчийн эрэлт хэрэгцээ сэтгэлд нийцсэн үйлчилгээг худалдан авах чадвартай байхын тулд

холбогдох журмыг санхүү, төсвийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Үндэсний зөвлөл батална.

тасралтгүй суралцагч хамт олон болох, эрүүл мэндийн байгууллагуудтайгаа хамтын ажиллагаагаа илүү чанаржуулан ажиллах зорилт тавин ажилласан байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогыг өмнөх оны орлогын гүйцэтгэлийг 2.0 дахин өсгөж үндэслэлгүй төлөвлөснөөс орлого 4.0 тэрбум төгрөгөөр тасарч авлага 226.3 сая төгрөгөөр өссөн байна.

1.4 Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого бодитоор төлөвлөөгүй, зарлагыг цахим хяналт хэрэгжүүлэн санхүүжүүлсэн байна.

Эрүүл мэндийн сангийн орлого, зарлагын төсвийг төлөвлөхдөө жил бүр ЭМДЕГ-аас ирүүлсэн “Төсвийн төсөл, төсөөллийн санал ирүүлэх тухай” албан тоот, Төсвийн тухай хууль, ЭМДҮ-ний Зөвлөлийн тогтоолын⁴ дагуу сангийн хөрөнгийн зарцуулалтын төсвийг тусламж үйлчилгээ үзүүлэх улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад олгохдоо оношны хамааралтай бүлгээр тухайн эрүүл мэндийн байгууллагын даатгалаас санхүүжих орны тоо, орны фонд ашиглалт, дундаж ор хоног, хүчин чадал, статистик тоо мэдээ, мэдээлэл, эрүүл мэндийн үйл ажиллагааны болон орон нутгийн онцлог, өвчлөлийн байдал зэрэг мэдээллийн санд үндэслэн төлөвлөсөн ч 2022 онд батлагдсан төсвийг дутуу бүрдүүлсэн байна. ЭМД-ын сангийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал: /Хүснэгт-1/

		Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын гүйцэтгэл /2020-2022 он/				/мян төгрөг/	
		2020		2021		2022	
А. ОРЛОГО		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
		5,173,224.0	4,405,750.7	4,857,374.6	5,424,579.1	10,618,104.2	6,603,521.9
1	ААНБ-аас төлөх шимтгэл	399,216.8	345,390.9	475,161.2	545,328.9	1,896,379.4	1,166,739.5
2	Ажиллагсадаас төлөх шимтгэл	2,280,583.4	1,979,990.7	2,118,962.2	2,428,297.0	4,774,640.7	2,941,471.5
3	Төсөвт байгууллагаас төлөх	1,908,898.9	1,660,133.1	1,686,608.3	1,933,619.6	2,955,271.6	1,820,472.6
4	Төрөөс хариуцах иргэдийн шимтгэл					6,856.1	6,817.0
5	Бусад даатгуулагчаас төлөх шимтгэл	572,362.2	416,420.1	572,362.2	515,015.7	984,956.4	666,903.4
6	Бусад орлого	12,162.7	3,815.9	4,280.7	2,317.9	0.0	1,117.9

Эх сурвалж: ЭМДЕГ-ын санхүүгийн тайлан

Дээрх хүснэгтээс харахад 2020 онд 5.1 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 4.4 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж орлого 0.7 сая төгрөгөөр тасарсан, 2021 онд 4.8 тэрбум төгрөгийн батлагдсанаас 5.4 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлж 0.6 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн, 2022 онд 10.6 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 6.6 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж 4.0 тэрбум төгрөгөөр орлого тасарсан байна. Шалтгаан нь: Нийгмийн даатгалын сангийн орлогын тайлангаар эрүүл мэндийн

⁴ Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн төсөл, төсөөлөл боловсруулахад баримтлах аргачлал”-ХОА-2023/19/ШТА-ГА/

даатгалд ноогдох хувь нь 14.56 байхад төлөвлөгөөгөөр 21 хувь байхаар төлөвлөсөн нь үндэслэлгүй байна гэж үзэж байна. Мөн өмнөх оны эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлогын гүйцэтгэлийг 2 дахин өсгөж баталсан нь үндэслэл муутай байна.

ЭМД-ын тухай хуулийн 19-р зүйлийн 19.3⁵-д заасны дагуу НДХ-ийн санд төвлөрсөн орлогын гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал: /Хүснэгт-2/

Аж ахуй нэгж байгууллагын ажил олгогч болон ажилтны төлөх шимтгэл, бусад даатгуулагчийн ЭМ орлогын дэлгэрэнгүй судалгаа							
№	Төрөл	2020 он		2021 он		2022 он	
		тоо	мөнгөн дүн	тоо	мөнгөн дүн	тоо	мөнгөн дүн
Заавал даатгуулах	Аж ахуй нэгж байгууллагын ажил олгогчийн төлөх шимтгэл/ аж ахуйн нэгж/	604	345,390.9	658	545,328.9	662	1,166,739.5
	Даатгуулагчийн төлөх шимтгэл	13956	1,979,990.7	13795	2,428,297.0	14417	2,941,471.5
	Төсөвт байгууллагын төлөх шимтгэл/байгууллага/	174	1,660,133.1	172	1,933,619.6	175	1,820,472.6
	НДШ-ийн авлага		89,111.3		150,797.0		226,293.1
Өөрөө хариуцах	Бусад даатгуулагчийн төлөх шимтгэл /өөрөө хариуцан төлөх/ Үүнээс:	8951	416,420.1	8,517	515,015.7	10070	666,903.4
	Малчин	3902	193,587.3	3445	227,857.3	3675	259,880.3
	Оюутан	1512	63,682.0	1097	58,384.4	635	39,900.7
	Хувиараа хөдөлмөр эрхлэгч	384	20,388.1	716	48,023.9	954	73,628.9
	Тодорхой ажил эрхлээгүй иргэд	3149	138,409.9	3258	180,682.9	4805	293,392.7
	Гадаадын иргэн харьяаттай хүн	4	352.8	1	67.2	1	100.8
Бусад орлого	Актын төлбөрөөр		1,672.5		1,843.1		683.4
	Чөлөөт сангийн үлдэгдэл хүү		1,930.4		247.7		-
	Торгууль		-		172.5		209.0
	Алданги		213.0		54.6		225.5

Эх сурвалж НДХ-ийн 2020-2022 оны санхүүгийн тайлан

Дээрх хүснэгтээс харахад 2021 онд өмнөх оноос 257 иргэн буюу 1018.9 сая төгрөг, 2022 онд өмнөх оноос 2999 иргэн буюу 1187.7 сая төгрөгөөр сангийн орлого өссөн байна.

ЭМД-ын шимтгэлийн авлага 2020 онд 89.1 сая, 2021 онд 150.8 сая төгрөг болж өмнөх оноос 61.7 сая, 2022 онд 226.3 сая төгрөг болж өмнөх оноос 75.5 сая төгрөгөөр өссөн байна. Өссөн шалтгаан нь аж ахуйн нэгж байгууллагууд НДШ-ийг он дамжуулан төлсөнтэй холбоотой байна. Үүнээс насжилт өндөртэй авлага 106.9 сая төгрөг байна.

⁵ Энэ хуулийн 19.1.1, 19.1.2, 19.1.8-д заасан шимтгэл, алдангийг цуглуулах, төвлөрүүлэх үйл ажиллагааг нийгмийн даатгалын байгууллага гүйцэтгэх бөгөөд үүнтэй холбогдсон харилцааг Нийгмийн даатгалын тухай хуулиар зохицуулна.

ЭМД-ын Үндэсний зөвлөлөөс баталсан 2021 оны 07⁶-р тогтоол, 2022 оны 12⁷-р тогтоолын дагуу 548 шалгуур үзүүлэлтээр хянаж ЭМД-аас 2021 онд 31.5 тэрбум, 2022 онд 36,0 тэрбум төгрөгийн тусламж үйлчилгээний санхүүжилт олгосон байна. Зардлын санхүүжилтийг нэр төрлөөр харуулбал: /Хүснэгт-3/

Ховд аймагт ЭМД-аас 2021-2022 онд олгосон тусламж үйлчилгээний зардлын санхүүжилт				
№	Тусламж үйлчилгээний төрөл	2021 он	2022 он	Зөрүү
		Санхүүжилт	Санхүүжилт	
1	Амбулаторийн тусламж үйлчилгээ	2,817,468.3	4,320,536.2	1,503,067.9
	Амбулаторийн үзлэг	935,980.9	1,244,569.1	308,588.2
	Үзлэг оношилгоо шинжилгээ	1,307,305.8	2,019,807.4	712,501.6
	Мэс ажилбар	29,500.0	60,193.0	30,693.0
	Шүд амны хөндийн үзлэг	148,815.0	339,801.0	190,986.0
	Хяналтын үзлэг	139,775.0	189,653.0	49,878.0
	Хэвийн явцтай жирэмсэн	101,602.2	89,067.1	(12,535.1)
	Эрсдэлтэй жирэмсэн	154,489.4	377,445.6	222,956.2
2	Өдрийн бусад эмчилгээ	198,800.0	313,332.0	114,532.0
	Диалез	198,800.0	307,000.0	108,200.0
	Өдрийн хорт хавдрын хими	-	6,332.0	6,332.0
3	Өдрийн эмчилгээ	421,949.1	859,920.0	437,970.9
	Өдрийн эмийн эмчилгээ	421,949.1	859,920.0	437,970.9
4	Өндөр өртөгтэй оношилгоо шинжилгээ	123,337.2	338,057.4	214,720.2
	Өндөр өртөгт	123,337.2	338,057.4	214,720.2
5	Хэвтүүлэн эмчлэх эмчилгээ	6,928,716.4	11,870,963.4	4,942,247.0
	Хэвтүүлэн эрчимт эмчилгээ	132,739.5	528,582.9	395,843.4
	Хэвтүүлэн эмийн эмчилгээ	5,941,777.3	9,192,654.9	3,250,877.6
	Хэвтүүлэн мэс засал эмчилгээ	728,989.0	1,933,681.2	1,204,692.2
	хими эмчилгээ	107,304.0	216,044.4	108,740.4
	Хими туяа	17,906.6	-	(17,906.6)
6	Хөнгөвчлөх үйлчилгээ	81,127.1	193,993.7	112,866.6
7	Уламжлалтын тусламж үйлчилгээ	184,883.9	355,474.7	170,590.8
	Уламжлалтын амбулатори	7,000.0	29,320.0	22,320.0
	Уламжлалтын өдөр	560.0	8,819.6	8,259.6
	Уламжлалтын хэвтэн үйлчилгээ	177,323.9	317,335.1	140,011.2
8	Сэргээн засах тусламж үйлчилгээ	8,660.0	217,430.6	208,770.6
	Сэргээн засах амбулатори	2,660.0	62,800.0	60,140.0
	Сэргээн засах өдөр	6,000.0	154,630.6	148,630.6
9	Яаралттай тусламж	635,845.0	1,845,890.0	1,210,045.0
	Яаралттай тусламж ерөнхий үйлчилгээ	214,245.0	1,369,739.0	1,155,494.0
	Яаралттай тусламж гэмтлийн үйлчилгээ	421,600.0	476,151.0	54,551.0
10	Түргэн тусламж	52,086.4	384,803.7	332,717.3
	Алсын дуудлага	8,596.4	141,280.7	132,684.3
	Ойрын дуудлага	43,490.0	243,523.0	200,033.0

⁶ Төсөв батлах тухай

⁷ Чанар, төлбөрийн хяналт хийх 2-р хавсралт

11	Урьдчилан сэргийлэх	138,693.4	72,623.0	(66,070.4)
12	Эрт илрүүлэг	-	175,354.0	175,354.0
13	Ковид	10,751,820.0	2,451,275.0	(8,300,545.0)
	ковид вакцин	650,005.0	40,815.0	(609,190.0)
	Ковид амбулатори	-	3,860.0	3,860.0
	Ковид хэвтэн	8,745,495.0	1,584,585.0	(7,160,910.0)
	Ковид гэр	1,356,320.0	646,400.0	(709,920.0)
	Сорьц шинжлэх /ПСР/	-	159,650.0	159,650.0
	Сорьц цуглуулах	-	15,965.0	15,965.0
14	Анхан шат	7,598,115.3	10,827,159.8	3,229,044.5
	Нэг иргэн /ТЗШ/	7,060,913.3	7,862,067.4	801,154.1
	ЭМД 4 багц тусламж	537,202.0	2,965,092.4	2,427,890.4
15	Төр хариуцах эм	55,796.0	72,488.0	16,692.0
16	Эм	1,500,660.3	1,699,865.1	199,204.8
	Энгийн эм	1,469,332.3	1,665,018.4	195,686.1
	В-ийн эм	26,498.0	34,846.7	8,348.7
	С-ийн эм	4,830.0	-	(4,830.0)
	Нийт	31,497,958.4	35,999,166.6	4,501,208.2

Дээрх хүснэгтээс харахад 2021 оноос даатгалын санхүүжилт 4.5 тэрбум төгрөгөөр өссөн харагдаж байгаа нь хүн амын өсөлт, тусламж үйлчилгээ авч байгаа хүний тоо өссөн, сумын ЭМТ, Өрхийн ЭМТ-өөр үйлчлүүлсэн иргэдэд даатгалаас санхүүжилт олгодог болсонтой холбоотой өссөн байна.

1.5 Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийг зохих журмын дагуу хянаж байгаа ч, хасагдал ихтэй байгаагаас тусламж үйлчилгээний чанар хүртээмж хангагдахгүй байх эрсдэл үүссэн байна.

Аймгийн ЭМДХ нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14-р зүйлийн 14.8.6⁸-р зүйл, 14.8.7⁹-р зүйл 16-р зүйлийн 1.5¹⁰-ыг үндэслэн Үндэсний зөвлөлийн 2022 оны 12-р тогтоолын 3.1.1¹¹, 3.1.2¹²-р зүйлд зааснаар хяналт хэрэгжүүлэхээр үүрэг хүлээсэн байна. ЭМД-аас санхүүжих гэрээт байгууллагуудын санхүүжилтийг ихэвчлэн цахимаар хяналт хэрэгжүүлэн олгосон байна. Аймгийн хэмжээнд цахим хяналт хэрэгжүүлэн олгосон санхүүжилтийг хүснэгтээр харуулбал: /Хүснэгт-4/

Ховд аймгийн ЭМБ-ын санхүүжилтийн тооцоо							
Д/Д	Он	Нэхэмжилсэн		Хасагдсан		Олгосон санхүүжилт	
		тоо	Мөнгөн дүн	тоо	Мөнгөн дүн	тоо	Мөнгөн дүн
1	2021 он	568356	32584.4	68989	8147.4	500606	24437.0

⁸ эрүүл мэндийн даатгалтай холбогдсон асуудлаар өөрийн бүрэн эрхийн хүрээнд холбогдох журам, тогтоол, зөвлөмж гаргах

⁹ даатгалын гэрээний дагуу худалдан авсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын болон төлбөрийн хяналтыг хэрэгжүүлэх журмыг олон улсын эмнэл зүйн удирдамж ашиглан батлах;

¹⁰ даатгуулагчид үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар болон зардлын төлбөрт хяналт тавьж, энэ хуулийн 14.8.7-д заасан журамд тусгагдсан шалгуур хангасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд төлбөр олгох;

¹¹ Нэхэмжлэлийн хяналт

¹² Байгууллага дээр очиж хяналт шалгалт хийх

2	2022 он	423886	40147.4	8342	3918.8	414542	35999.2
Дүн		992242	72,731.8	77331	12,066.2	915148	60,436.2

Эрүүл мэндийн байгууллагууд 2020-2021 оны байдлаар 72.7 тэрбум төгрөг нэхэмжилж 12.1 тэрбум төгрөгийн хасалт хийлгэж 60.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг түүврийн аргаар эх олонлогт харьцуулан хяналт хэрэгжүүлж цахим хасалт хийгдсэн байгаа нь бодит гүйцэтгэлд нөлөөлж байна. Тухайлбал:

- ✓ Чанар, төлбөрийн хяналт хийж журмын 2022 оны 12-р тогтоолын 4.1.2.3¹³-д заасны дагуу нэхэмжлэлийн хяналтаар хасагдсан тохиолдлын дэлгэрэнгүй тайланг эрүүл мэндийн байгууллагуудад сар бүр гаргаж хүргүүлээгүй
- ✓ Эрүүл мэндийн байгууллагууд тусламж үйлчилгээний санхүүжилтийн гүйцэтгэлд хяналт хэрэгжүүлээгүй, хасагдсан тохиолдлын дэлгэрэнгүй тайланг авч дүн шинжилгээ хийгээгүй, хасагдлыг бууруулах талаар ажил зохион байгуулаагүй
- ✓ Гэмт хэрэг, зөрчлийн улмаас эрүүл мэнд нь хохирсон даатгуулагчийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардлын төлбөрийг ЭМД-ын сангаас олгосон, түүнийг буруутай этгээдээр төлүүлэх талаар арга хэмжээ аваагүй
- ✓ Эрүүл мэндийн байгууллага нь ЭМДЕГ-тай байгуулсан гэрээнд үзүүлэх тусламж үйлчилгээний нэр төрлийг тоо хэмжээ, шалгуур үзүүлэлтээс хэтрүүлж нэхэмжилсэн нь нөлөөлж үзүүлсэн үйлчилгээний төлбөрийг авч чадахгүй байгаа байдал нөлөөлсөн

1.6 Эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь ЭМДЕГ-т харьяалагдаж сангийн орлогыг дамжуулан зарцуулах үүрэг гүйцэтгэж байна.

Аймгийн эрүүл мэндийн даатгалын хэлтсийн орон тоог Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2020 оны 11-р сарын 30-ны 17 тоот тогтоолыг үндэслэн ЭМДЕГ-ын 2022 оны 01-р сарын 24-ны А/10 тоот тушаалаар хэлтсийн дарга 1, чанар төлбөр хариуцсан мэргэжилтэн 4 нийт 5 орон тоогоор баталсан байна. Хэлтсийн мэргэжилтэн нар ажлын байрны тодорхойлолтын дагуу ажиллаж байгаа ч дараах хүндрэл бэрхшээл байна: Тухайлбал:

- ✓ Аймгийн эрүүл мэндийн даатгалын байгууллага нь ЭМД-ын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5.1¹⁴-д заасныг хэрэгжүүлээгүй, аймгийн хэмжээний статистик тоон мэдээлэлгүй, эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, эрүүл мэндийн байгууллагуудад олгосон тусламж үйлчилгээний санхүүжилтийн талаарх судалгаа мэдээлэл дутмаг тоон мэдээлэл ЭМДЕГ-т төвлөрдөг
- ✓ Чанар, төлбөрийн хяналт хийж нэхэмжлэлийн хяналтаар хасагдсан тохиолдлын дэлгэрэнгүй тайланг ЭМДҮЗ-ийн 2022 оны 8 дугаар сарын 11-ний 12 дугаар тогтоолын 4.1.2.3¹⁵-д заасны дагуу албан тоотгоор хүргүүлж байгаач хэрэгжилт хангалтгүй
- ✓ ЭМБ-аас ирүүлсэн нэхэмжлэлийг цахимаар хянаж санхүүжилтийг ЭМДЕГ-т илгээн

¹³ Чанар, төлбөрийн хяналт хийсэн нэхэмжлэлийн хяналтын тайланг гаргах, дүн шинжилгээ хийх, нэхэмжлэлийн хяналтаар хасагдсан тохиолдол тус бүрээр хавсралтад заасан загварын дагуу дэлгэрэнгүй тайланг сар бүр гаргаж ЭМБ-д хүргүүлэх, эргэх холбоо тогтоох, иргэн даатгуулагчийн холбогдох мэдээллээр хангах”

¹⁴ "орлого зарлагын тайланг сум, дүүргийн эрүүл мэндийн байгууллага тухайн улирлын дараа сарын 15-ны дотор, аймгийн эрүүл мэндийн даатгалын байгууллага тухайн улирлын дараа сарын 25-ны дотор эрүүл мэндийн даатгалын байгууллагад тус тус ирүүлэх"

¹⁵ "Чанар, төлбөрийн хяналт хийсэн нэхэмжлэлийн хяналтын тайланг гаргах, дүн шинжилгээ хийх, нэхэмжлэлийн хяналтаар хасагдсан тохиолдол тус бүрээр хавсралтад заасан загварын дагуу дэлгэрэнгүй тайланг сар бүр гаргаж ЭМБ-д хүргүүлэх,

олгож байгаа ч чанар төлбөрийн нэхэмжлэлийг ажлын ачаалал ихээс газар дээр нь очиж хяналт хэрэгжүүлэх, зөвлөмж тусламж үзүүлэх, мэдээллээр бүрэн хангах нөхцөл бүрдээгүй

1.7 Эрүүл мэндийн байгууллагын сонгон шалгаруулах үйл ажиллагааг ЭМДЕГ зохион байгуулсан байна.

Ховд аймгийн хэмжээнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж байгаа, тусгай зөвшөөрөлтэй, магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх чадамж, хүртээмжийг нь харгалзан иргэдэд үзүүлэх тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор ЭМДҮЗ-ийн 2022 оны 02 тоот тогтоолд заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журмын дагуу 2022 оны байдлаар төрийн өмчийн 2, хувийн хэвшлийн 5, эмийн сан 39, өрхийн ЭМТ 6, сумын ЭМТ 15 эрүүл мэндийн байгууллагатай гэрээ байгуулан ажилласан байна. Сонгон шалгаруулалт үр дүнгүй байх эрсдэл байна. Үүнд:

- ✓ Сонгон шалгаруулалтын эцсийн үр дүнг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын цахим хуудсанд байршуулж мэдээлж байгаа ч сонгон шалгаруулалтад оролцсон хувийн хэвшлийн эмнэлгийн байгууллагад улсын эрүүл мэндийн байгууллагад ажилладаг эмч эмнэлгийн ажилчид давхар ажиллаж байгаад хяналт хэрэгжүүлээгүй байна.
- ✓ Хувийн хэвшлийн эмнэлгүүд даатгалаас санхүүжилт авахын тулд төрийн байгууллагын эмч, ажилчдын бичиг баримт ашигласан байх магадлалтай байна.

1.8 Өрхийн ЭМТ, Эмийн сантай байгуулсан гэрээгээ дүгнэсэн байгаач бусад байгууллагын гэрээг дүгнэж үр дүнг тооцоогүй байна.

Эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь 2021-2022 онд хувийн эмийн сангууд, Өрхийн ЭМТ, Сумын эрүүл мэндийн төвүүдийн гэрээг дүгнэж 70-80 хувьтай дүгнэгдсэн эрүүл мэндийн байгууллагад албан шаардлага хүргүүлсэн байна. Тухайлбал:

- ✓ Эрүүл мэндийн төвийн тусламж, үйлчилгээ үзүүлсэн анхан шатны, бүртгэлийг бүрэн хөтөлж хэвшээгүй, дутуу
- ✓ Үзүүлж байгаа тусламж, үйлчилгээ бодитой, чанартай эсэх, үр дүнг тооцож, үнэлгээ дүгнэлт хийж ажиллаагүй
- ✓ Байцаагчийн эмчийн хяналтаар илэрсэн 5 дээш хасагдалтай ажилласан.
- ✓ Нэхэмжлэл жагсаалтай холбоотой хасагдалтай ажилласан
- ✓ Эрүүл мэндийн даатгалын хууль, тогтоомжийг сурталчлан, ил тод байршуулан ажиллаагүй
- ✓ Тусламж үйлчилгээтэй холбоотой даатгуулагчийн санал гомдол 3- аас дээш удаа ирсэн зэрэг шалгуур үзүүлэлтийг тус тус хангаж ажиллаагүй

Эмийн сангийн гэрээг 77-81,3 хувьтай дүгнэж дараах албан шаардлага хүргүүлсэн байна. Тухайлбал:

- ✓ Нийгмийн даатгалын тайлан мэдээг нийгмийн даатгалын байгууллагад хуулийн хугацаанд хүргүүлж, нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр төлж ажилладаггүй
- ✓ Аж ахуй нэгжийн орлогод эрүүл мэндийн даатгалын сангаас хуваарилсан хөрөнгийн эзлэх хувийг тооцоож гаргаагүй
- ✓ Стандартад заасан анхан шатны маягт, бүртгэлийг бүрэн хөтөлж хэвшээгүй,
- ✓ Даатгуулагчдын санал хүсэлт, сэтгэл ханамжийн судалгааны дүн, дүгнэлт авч хэрэгжүүлсэн арга хэмжээгүй
- ✓ Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх эмийн жагсаалтыг ил тод байршуулан ажиллаагүй
- ✓ Эмийн жор бичилтэд тогтмол хяналт үнэлгээ хийж, зохистой жор бичилтийг

төлөвшүүлэхэд харьяа нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагын эмнэлгийн мэргэжилтэнтэй хамтран ажиллаагүй

Дээрх албан шаардлагаар өгсөн үүрэг даалгаврыг 9 аж ахуйн нэгж хангалтгүй биелүүлсэн байна.

1.9 Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж буй эрүүл мэндийн байгууллагад 992242 тохиолдлын 72.7 тэрбум төгрөгийн төлбөр нэхэмжилж 77331 тохиолдлын 12.1 тэрбум төгрөгийн хасагдал гарч 915948 тохиолдлын 60.4 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Аймгийн эрүүл мэндийн салбарт нийт 1444 ажилтан ажиллаж байгаагаас их эмч 304, эм зүйч 72, сувилагч 363, багийн бага эмч 59, эх баригч 45, лаборант 43, техникч 16, эм найруулагч 59, бусад бага эмч 72, бусад ажилчид /Удирдах албан тушаалтан-15, НЭМ мэргэжилтэн-33, мэдээлэл технологийн инженер-5, эмнэлгийн тоног төхөөрөмж, бусад дээд мэргэжилтэн -68, бусад ажилчид 261 тус тус ажиллаж байна.

ЭМС-ын 139 дүгээр тушаал болон Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 4 сарын 5-ны өдрийн 6¹⁶ дугаар тогтоолын дагуу “Эрүүл мэнд - үндэсний баялаг” уриан дор хийгдэж буй урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэг, оношилгоо, шинжилгээг эрчимжүүлэх, хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилгоор Эрүүл мэндийн газраас санаачлан 2022 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр аймгийн Засаг даргын тамгын газар, эрүүл мэндийн даатгалын хэлтэс, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, сум, өрхийн эрүүл мэндийн төв, хувийн хэвшлийн эмнэлгүүдийн төлөөлөл оролцуулсан уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан байна.

Эрүүл мэндийн газрын даргын А/279 дугаар албан тоот хүргүүлж 16 сум, 6 өрхийн эрүүл мэндийн төвд нийт 22 ажлын хэсэг 89 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж эрт илрүүлэг үзлэгийг зохион байгуулжээ. Эрүүл мэндийн сайдын 2022 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн А/139 дугаар тушаалыг өрх, сумын эрүүл мэндийн төвүүдэд хүргүүлж, эрт илрүүлэх хамрагдах иргэдийн судалгааг авч нэгтгэхэд 0-5 нас 5445, 6-17 нас 22085, 18-30 нас 19049, 31-45 нас 17611, 46-60 нас 12701, 60-аас дээш нас 5649 нийт 90333 хүн хамрагдахаар байгаа ба жилийн эцсийн байдлаар 16 хувийн хамрагдалтай байна.

Эрүүл мэндийн даатгалаас санхүүжиж байгаа эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааг түүвэрлэн үзэхэд:

Баруун бүсийн оношилгоо эмчилгээний төвийн талаар:

ТУЗ байгуулагдаагүй, дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй, эдийн засгийн үр ашгийг тооцоогүй, мэдээллийн ил тод байдлыг бүрэн хангаагүй байна.

Ховд аймаг дахь Бүсийн оношилгоо, эмчилгээний төв нь бүс нутгийн хүн амд эрүүл мэндийн үндсэн болон төрөлжсөн мэргэшлийн лавлагаа тусламж, үйлчилгээг үзүүлэх, эрдэм шинжилгээ, судалгаа, сургалт, сурталчилгаа хийх чиг үүрэг бүхий байгууллага юм.

¹⁶ Даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо шинжилгээнд хамруулах, төлбөрийг нь санхүүжүүлэх журмын 1-р хавсралт, Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгийн багц төлбөр 2-р хавсралт

БОЭТ нь 2020-2022 онуудад эрүүл мэндийн даатгалаас 598 нэр төрлийн тусламж үйлчилгээ үзүүлж санхүүжилт авахаар гэрээ байгуулан үйл ажиллагаагаа явуулж байна. Орлого зарлагын санхүүжилтийг хүснэгтээр харуулбал: /Хүснэгт-5/

Санхүүжилтийн орлого зарлагын үзүүлэлт					
Д/Д	ЭМТөвийн нэрс	Олгосон санхүүжилт			2022 оны харилцахын үлдэгдэл
		2020 он	2021 он	2022 он	
1	Санхүүжилт	5,402.1	16,361.6	18,262.2	66.2
2	Хөрөнгө оруулалт	18,838.7	2,067.3	1,924.8	
3	Цалин	6,393.0	7,505.8	9,045.7	
4	Авлага	7.2	3,614.9	1,503.5	
5	Өглөг	-	0.7	-	
6	Эм, боох материал	1,932.2	3,505.4	4,999.5	
Нийт		32,573.2	33,055.7	35,735.7	66.2

Дээрх хүснэгтээс харахад ЭМД-ын санхүүжилт 2021 онд өмнөх оноос 10.9 тэрбум, 2022 онд өмнөх оноос 1.9 тэрбум төгрөгөөр өссөн, цалингийн сан 2021 онд өмнөх оноос 1.1 тэрбум, 2022 онд өмнөх оноос 1.5 тэрбум төгрөгөөр өссөн, хөрөнгө оруулалт 2022 онд өмнөх оноос 16.7 тэрбум 2022 онд өмнөх оноос 142.5 сая төгрөгөөр буурсан, эм боох материал 2021 онд өмнөх оноос 1.5 тэрбум 2022 онд 1.4 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Тайлант онд авлага 2.1 тэрбумаар буурч өглөг үүсээгүй байна.

Бүс нутгийн хүн амд чанар байдлыг эрхэмлэн, сонголтод суурилсан, үйлчлүүлэгчид ээлтэй, тэгш хүртээмжтэй, эмнэлгийн тусламж үйлчилгээг чадварлаг багаар үзүүлнэ гэсэн зорилт тавин ажилласан байна. Зорилтынхоо хүрээнд дараах үр дүнтэй ажлуудыг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- ✓ Тусламж, үйлчилгээний нөөцийн бүрдүүлэлт хийсэн
- ✓ Үйлчлүүлэгч болон ажилчдад ээлтэй тохитой орчныг бүрдүүлсэн
- ✓ Ажилчдын нийгмийн хамгааллыг сайжруулах ажлыг эхлүүлж 2023 оны төсвийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4.5 тэрбум төгрөгийн хөрөнгийн санхүүжилт батлуулсан
- ✓ Тусламж, үйлчилгээний тэргүүлэх чиглэл Брэнд тусламжийг нэвтрүүлсэн
- ✓ Тусламж, үйлчилгээний чанар сайжруулах олон талт ажлыг төлөвлөж хэрэгжүүлдэг болсон

Тус төв нь 2018-2022 оны тоон статистик үзүүлэлтээр жилд дунджаар амбулаторийн үзлэгээр 142380, урьдчилан сэргийлэх үзлэгээр 15906, хэвтэн эмчлүүлэгчээр 12418, мэс засал 1910, 1831 төрөлт, 8426 яаралтай тусламж, 182 алсын дуудлагаар тус тус үйлчлүүлэгчдэд үндсэн болон төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээг үзүүлсэн байна.

Аудитын явцад даатгалын гэрээний хэрэгжилт, санхүүжилтийн гүйцэтгэлд түүвэрлэн хяналтыг хэрэгжүүлэхэд дараах зөрчил дутагдал илэрлээ. Тухайлбал

- ✓ Эрүүл мэндийн нэмэлт үзлэг, оношилгоонд хамрагдсан багш нарын эрүүл мэндийн үзлэг, оношилгооны ерөнхий мэдээллийг баталгаажуулан зөвлөмжийн хамт Төсвийн шууд захирагчид хүргүүлээгүй, ЭМЯ-ны мэдээллийн санд бүртгээгүй
- ✓ ТУЗ байгуулаагүй, эм, эмийн хэрэгсэл, хөрөнгө оруулалт, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй тендерийн эм нийлүүлж байгаа аж ахуйн нэгжүүдийн гэрээний биелэлт хангалтгүй,
- ✓ БОЭТ нь 2021-2022 онуудад давхардсан тоогоор 357390 даатгуулагчдад тусламж үйлчилгээ үзүүлж 41.6 тэрбум төгрөгийн төлбөр нэхэмжилснээс 32.8 тэрбум төгрөгийн санхүүжилт авч 8.8 тэрбум төгрөг буюу нийт нэхэмжилсэн төлбөрийнхөө 40%, 2022 онд 13.6%-ийг хасуулсан байна.
- ✓ Санхүүгийн үйл ажиллагаанд үр ашгийн тооцоо, шинжилгээг бодитой хийгээгүйгээс орлого зарлагын үр нөлөөг дүгнэх боломжгүй, Монгол улсын Сангийн сайдын 2015 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 343¹⁷ дугаар тушаалын дагуу санхүүгийн шинжилгээ хийх заавар аргачлалыг хэрэгжүүлээгүй
- ✓ Байгууллагад эдийн засагч нар ажиллаж байгаа ч ЭМД-аас гүйцэтгэлээр санхүүжих болсонтой холбоотой эдийн засгийн үр ашгийг 5 жилээр гаргаж тооцоогүй нь мэргэжлийн ур чадвартай мэргэжилтэн дутмаг, мэдээлэлгүй байгаа нь санхүүгийн хүндрэл үүсэх магадлал өндөр
- ✓ Эрүүл мэндийн даатгалын цахим мэдээллийн системийн хөгжүүлэлт шаардлага хангахгүй, мэдээллийн ил тод, нээлттэй байдал бүрэн хангагдаагүй, төлбөрийн нэхэмжлэл бодит гүйцэтгэлээр ирэхгүй хасагддаг, шалгуур үзүүлэлт нь амьдралд нийцээгүй, санхүүжилтийн үр дүн гарахгүй тусламж үйлчилгээний чанар алдагдах бэрхшээл үүссэн байна.
- ✓ Эмч эмнэлгийн ажилчид хувийн эмнэлгүүдэд давхар ажиллаж байгаа нь иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар муудах, дараалал хүлээгдэл үүсэх эрсдэлтэй байгаа зэрэг зөрчлүүд илэрлээ.

Сумдын эрүүл мэндийн төвийн даатгалын санхүүжилтийн талаар:

ЭМД-аас санхүүжилт авч харилцахын зарцуулаагүй үлдэгдэлтэй байгаа ч зарим эрүүл мэндийн газрууд 46.7 сая төгрөгийн өр төлбөртэй байна.

Сумдын эрүүл мэндийн төвүүд 2020 онд 1060,9 сая, 2020 онд 3358.1 сая төгрөг буюу өмнөх оноос 2297.2 сая төгрөгөөр гүйцэтгэлд суурилсан санхүүжилт өссөн, 2022 онд 11848.3 сая төгрөгийн гүйцэтгэлд суурилсан санхүүжилт авч өмнөх оноос 8490.2 сая төгрөгөөр өссөн байна. Тусламж үйлчилгээний санхүүжилтийг хүснэгтээр харуулбал: /Хүснэгт-6/

Сумдын Эрүүл мэндийн байгууллагад олгосон санхүүжилт							
Д/Д	ЭМТөв-ийн нэрс	Олгосон санхүүжилт			2022 оны харилцахын үлдэгдэл	Эмийн үлдэгдэл	Өр төлбөр
		2020 он	2021 он	2022 он			
1	Алтай СЭМТ	33.0	184.0	684.0	25.2	18.9	1.6
2	Булган СЭМТ	536.6	1,290.4	2,111.7	1.1	136.3	19.9
3	Буянт СЭМТ	34.2	105.2	552.3	12.2	11.3	0.7

¹⁷ тушаалын хавсралтаар баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд шинжилгээ хийх үлгэрчилсэн аргачлал”

4	Дарви СЭМТ	30.4	171.1	769.0	137.9	31.8	0.8
5	Дөргөн СЭМТ	18.0	106.3	615.2	127.9	12.5	0.4
6	Дуут СЭМТ	19.6	120.1	463.2	21.3	2.1	
7	Зэрэг СЭМТ	32.8	156.1	762.4	75.3	38.8	0.8
8	Манхан СЭМТ	43.1	206.5	690.2	90	62.5	
9	Мөнххайрхан СЭМТ	22.4	120.5	521.4	24.4	49.8	4.9
10	Мөст СЭМТ	97.9	111.4	732.6	3.7	53.8	6.3
11	Мянгад СЭМТ	36.7	111.0	669.0	54	26.9	
12	Үенч СЭМТ	34.4	99.2	738.0	101.6	55.8	
13	Ховд СЭМТ	36.0	117.1	524.4	21	1.4	10.9
14	Цэцэг СЭМТ	30.8	270.4	780.0	56.4	38.3	
15	Чандмань СЭМТ	31.0	137.2	736.9	26.3	48.6	0.3
16	Эрдэнэбүрэн СЭМТ	24.0	51.6	498.0	8.8	14.6	0.1
17	Нийт	1,060.9	3,358.1	11,848.3	787.1	603.4	46.7

Дээрх хүснэгтээс харахад Булган сумын Нэгдсэн эмнэлэг 19.9 сая төгрөг, Ховд сумын ЭМТ 10.9 сая төгрөг, Мөст сумын ЭМТ 6.3 сая төгрөг, Мөнххайрхан сумын ЭМТ 4.9 сая төгрөгийн өртэй харагдаж байна. Харилцах дансанд Дарви сум 137.9 сая, Дөргөн сум 127.9 сая, Үенч сум 101.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Хувийн хэвшлийн эмнэлгүүдийн үйл ажиллагааны талаар:

Хувийн эмнэлгийн тусламж үйлчилгээнд хамрагдагчийн тоо өмнөх оны үзүүлэлтээс хүний тоо 50 хувь өссөн, олгосон санхүүжилт 1,026,0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх байгууллагын сонгон шалгаруулах журмын дагуу сонгон шалгаруулалтад тэнцсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч, ор бүхий 6 хувийн эмнэлэг ЭМДЕГ-тай гэрээ байгуулан орон нутагт эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлж байна. Тусламж үйлчилгээг хүснэгтээр харуулбал: /Хүснэгт-7/

Хувийн хэвшлийн эмнэлгүүдийн үзүүлэх тусламж үйлчилгээ					
Д/д	Хувийн хэвшлийн ЭМБ	1.2. Хувийн хэвшлийн эрүүл байгууллага	2.1Амбулаторийн тусламж, үйлчилгээ	5.2. Өдрийн эмийн эмчилгээ	9.2 Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээ
1	Ач заяа эмнэлэг	Уламжлалт эмчилгээ, дотор, мэс засал, хавдрын эмнэлэг	Хэвтүүлэн эмчлэх	Хэвтүүлэн эмчлэх	Хэвтүүлэн эмчлэх
2	Мөнгөн морьт эмнэлэг	Дотор, эмэгтэйчүүдийн эмнэлэг, мэдрэлийн өвчний оношилгоо, эмчилгээ, сэргээн засах тусламж, амбулаторийн үзлэг, өдрийн эмчилгээ	Дотор, эмэгтэйчүүдийн эмнэлэг, мэдрэлийн өвчний оношилгоо, эмчилгээ, сэргээн засах тусламж, амбулаторийн үзлэг, өдрийн эмчилгээ	Дотор, эмэгтэйчүүдийн эмнэлэг, мэдрэлийн өвчний оношилгоо, эмчилгээ, сэргээн засах тусламж, амбулаторийн үзлэг, өдрийн эмчилгээ	
3	Мөнхцохилохуй хувийн эмнэлэг	Дотор,Зүрх судасны оношилгоо эмчилгээ, Уламжлалт анагаах ухаан, сэргээн засах тусламж үйлчилгээ	Дотор,Зүрх судасны оношилгоо эмчилгээ, Уламжлалт анагаах ухаан, сэргээн засах тусламж үйлчилгээ	Дотор,Зүрх судасны оношилгоо эмчилгээ, Уламжлалт анагаах ухаан, сэргээн засах тусламж үйлчилгээ	Дотор,Зүрх судасны оношилгоо эмчилгээ, Уламжлалт анагаах ухаан, сэргээн засах

		тусламж үйлчилгээ
4	Очир сүлд эмнэлэг	Мэдрэл нөхөн сэргээх эмчилгээ
5	Жаргалант- удам эмнэлэг	Уламжлалт
6	Ачлалт наран хайрхан	Уламжлалтын тусламж, үйлчилгээ

Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2022 оны 01сарын 28-ны өдрийн 02 дугаар тогтоолын хавсралтын дагуу сонгон шалгаруулалтад оролцогч нь эрүүл мэндийн тухай хуулийн 19.1-д¹⁸ заасан эрүүл мэндийн байгууллага нь зөвхөн тусгай зөвшөөрөлд заасан тусламж, үйлчилгээний төрлийн хүрээнд сонгон шалгаруулалтад орох бөгөөд “Ерөнхий шаардлага” болон “Тусгай шаардлага” гэсэн үндсэн 2 төрлийн шаардлагыг хангасан байх, хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний төрлийн сонгон шалгаруулалтад зөвхөн аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын тушаалаар баталсан ор бүхий эрүүл мэндийн байгууллага оролцоно гэсэн заалтуудыг хангасан байна.

Ховд аймгийн хэмжээнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч 6 хувийн эмнэлэг өөрийн тусгай зөвшөөрөлд заагдсан үйл ажиллагааны хүрээнд гэрээний хавсралтад заасан хүний эрүүл мэндийн хэрэгцээ шаардлагад нийцсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүн амд анагаах ухааны нотолгоонд суурилсан аргаар, чанартай, аюулгүй, шуурхай үзүүлэх зорилгын хүрээнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг худалдан авах даатгалын гэрээний дагуу санхүүжсэн байна. Хувийн эмнэлгүүдийн тусламж үйлчилгээг хүснэгтээр харуулбал: /Хүснэгт-8/

Хувийн хэвшлийн эмнэлгүүдийн санхүүжилтийг 2 жилээр харуулбал													
№	Эрүүл мэндийн байгууллагын нэрс	2021 он						2022 он					
		Нэхэмжилсэн		Хасагдсан		Олгосон санхүүжилт		Нэхэмжилсэн		Хасагдсан		Олгосон санхүүжилт	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Ач заяа эмнэлэг	725	578.3	34	54	691	524.3	1634	1,069.8	51	93.8	1561	975.6
2	Мөнгөн морьт эмнэлэг	955	478.5	46	19.9	909	458.6	1516	740.4	24	24	1365	716.3
3	Мөнхцохилохуй хувийн эмнэлэг	576	175.6	28	12	548	163.6	1248	545.0	12	13.3	1236	531.7
4	Очир сүлд эмнэлэг	323	531.7	32	11.9	291	519.8	477	188.9	5	20.1	446	168.7
5	Жаргалант-удам эмнэлэг	598	312	25	13.2	573	298.8	1326	477	15	11.8	1311	465.1
6	Ачлалтнаран хайрхан	0	0	0		0	0	357	81.5	8	4.9	349	76.5
	Хувийн эмнэлгийн дүн	3177	2,076.1	165	111.0	3012	1,965.1	6558	3,102.8	115	168.3	6268	2,934.5

Хүснэгтээс харахад 2021, 2022 онуудад 9735 хүнд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлж 5,178.9 сая төгрөгийн санхүүжилт нэхэмжилснээс ЭМДХ-ийн хяналтаар 280 хүний 279.3 сая төгрөгийн алдаатай гүйцэтгэл хасагдаж 9280 хүний 4,899.6 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Аудитын явцад даатгалын гэрээний хэрэгжилт, санхүүжилтийн гүйцэтгэлд хяналтыг хэрэгжүүлэхэд дараах зөрчил дутагдал илэрлээ. Тухайлбал

¹⁸ Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх хэрэгцээний тодорхойлолт бүхий зориулалтын барилга байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, хүний нөөцийн зохих шаардлага хангасан өмчийн аль ч хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагад эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл /цаашид "тусгай зөвшөөрөл" гэх/ олгоно.

- ✓ Хувийн эмнэлгийн тусламж үйлчилгээний гүйцэтгэлд аймгийн ЭМДХ-ийн нэг мэргэжилтэн түүврийн хэмжээнд хяналтын хэрэгжүүлж байгаа нь гүйцэтгэлийн хяналт цар хүрээ багатай бодитой, үр дүнтэй хэрэгжих боломж хангалттай бус, хуурамч нэхэмжлэл илгээх, оношны код ахиулж нэхэмжлэх, завших оролдлого үүсэх эрсдэл их байна,
- ✓ Эрүүл мэндийн даатгалын сангаас 2021 онд санхүүжүүлэх тусламж үйлчилгээний зардлыг Ач заяа эмнэлэгт тухайн оны гүйцэтгэлээс 32.1 сая төгрөгөөр илүү олгож авлагаар бүртгэсэн, 2022 онд Очир сүлд эмнэлэгт 9.6 сая төгрөг илүү олгосон
- ✓ Ач заяа, Мөнх цохилохуй, Мөнгөн морьт, Ивээл, Жаргалант удам эмнэлгүүд иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ, төлбөрийн хэмжээний хавсралтад амбулаторийн үйлчилгээ үзүүлэхэд иргэдээс төлбөр хураамж авахгүй гэсэн байгаа боловч газар дээр хяналтыг хэрэгжүүлэхэд 20000-23000 төгрөгийн төлбөр авч байгаа зөрчил дутагдал илэрсэн
- ✓ Мөн гэрээний 2 дугаар хавсралтаар Ач заяа эмнэлэг иргэн даатгуулагчийн хүсэлтээр үзүүлэх нэмэлт үйлчилгээ 10000 төгрөг, Мөнх цохилохуй эмнэлэг гэрээний 4 дүгээр хавсралтаар 1 ортой 20000 төгрөг, 2 ортой өрөөнд 10000 төгрөгийн нэмэлт үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулсан,
- ✓ Аудитаар Очир сүлд эмнэлгийн үйлчлүүлэгч тус эмнэлэгт 7 хоног эмчилгээ үйлчилгээ аваад эмнэлгээс гараад 2 хоногийн дараа аймгийн БОЭТ-д эмчид үзүүлж үйлчилгээ авах гэсэн боловч өмнөх хэвтсэн эмнэлгийн эмчилгээний стор хаагдаагүй байсан зөрчил дутагдал илэрлээ.

Эмийн сангийн үйл ажиллагааны талаар:

Даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх эмийн тоо өмнөх оны үзүүлэлтээс 20 хувь өссөн, олгосон санхүүжилт 195.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Ховд аймгийн хэмжээнд хүн амыг эм, эмнэлгийн хэрэгслээр жижиглэнгийн үнээр хангах үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий эм зүйн тусламж үйлчилгээ үзүүлэх нийтийн үйлчилгээний нэгдүгээр зэрэглэлийн 8 хоёрдугаар зэрэглэлийн 20, эмнэлгийн 2, сумдын эргэлтийн эмийн сан 15 нийт 45 эмийн сан үйл ажиллагаа явуулж байна.

Аймгийн Эрүүл мэндийн газрын эмийн бодлого чанар аюулгүй байдал, эмийн ханамж хариуцсан мэргэжилтэн оролцсон ажлын хэсэг 2022 онд эмийн сангийн үйл ажиллагаа явуулж байгаа 15 аж ахуйн нэгж байгууллагад эмийн санд тавих нийтлэг шаардлага MNS 5262:2015 стандартын хэрэгжилтэд хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж илэрсэн зөрчил дутагдалд хугацаатай зөвлөмжүүдийг хүргүүлэн ажилласан боловч зөвлөмжийн хэрэгжилт хангагдаагүй, хэрэгжилтийг хангуулан ажиллах талаар тодорхой бодлого хэрэгжүүлэн ажиллаагүй байна. Стандартын хэрэгжилтэд хийсэн үнэлгээг хүснэгтээр харуулбал: /Хүснэгт-9/

Эмийн санд тавих нийтлэг шаардлага MNS 5262:2015 стандартын хэрэгжилтэд хийсэн үнэлгээ			
№	ЭМИЙН САНГИЙН НЭР	MNS 5260:2015 СТАНДАРТЫН ХАНГАЛТЫН ХУВЬ	ТАЙЛБАР
1	Сод-Очир тун	95%	Эмийн сангийн эрхлэгч нь эм зүйн албаны менежментийн чиглэлээр мэргэших сургалтад хамрагдсан байх заалтыг хэрэгжүүлэх

2	Алтангагнуур	94%	Эмийн сангийн эрхлэгч нь эм зүйн албаны менежментийн чиглэлээр мэргэших сургалтад хамрагдсан байх заалтыг хэрэгжүүлэх
3	Алтан-агь-энх	89.7%	Эмийн сангийн эрхлэгч нь эм зүйн албаны менежментийн чиглэлээр мэргэших сургалтад хамрагдсан байх заалтыг хэрэгжүүлэх
4	Нандин тун	86%	
5	Вансэмбэрүү-1	84.9%	Байрны халаалтын асуудал
6	Ачит-алтан хундага	84.9%	
7	Ховд Монос	82.6%	Эмийн сангийн эрхлэгч нь эм зүйн албаны менежментийн чиглэлээр мэргэших сургалтад хамрагдсан байх заалтыг хэрэгжүүлэх
8	Вансэмбэрүү-2	82.3%	Эмийн сангийн эрхлэгч нь эм зүйн албаны менежментийн чиглэлээр мэргэших сургалтад хамрагдсан байх заалтыг хэрэгжүүлэх
9	Маралжин	70%	заавар дүрэм журам бүртгэл бичиг цаас хангалтгүй хэмжээнд байгаа
10	Хишигбүрэн	71%	заавар дүрэм журам бүртгэл бичиг цаас хангалтгүй хэмжээнд байгаа
11	Өгөөмөр 5 салаа	63.9%	заавар дүрэм журам бүртгэл бичиг цаас хангалтгүй хэмжээнд байгаа
12	Түмний ачит тунгалаг	62%	заавар дүрэм журам бүртгэл бичиг цаас хангалтгүй хэмжээнд байгаа /Эрхлэгч декриттэй/
13	Хан хөхий	57.2%	1 мэргэжлийн боловсон хүчин дутуу
14	Монос маркет	52%	Эрхлэгч тогтвор суурьшилгүй ажиллаж байгаа
15	Хос шүүдэргэнэ	47.9%	1 мэргэжлийн боловсон хүчин дутуу
	Дундаж	75%	

Эх сурвалж: ЭМГ

Дээрх хүснэгтээс харахад стандартын хэрэгжилтэд хийсэн дундаж үнэлгээ хангалтгүй 75%-тай байгаа нь мэргэжлийн боловсон хүчин дутуу, мэргэших сургаалтанд хамрагдаагүй, бичиг баримтын зөрчилтэй холбоотой байна.

Ховд аймгийн хэмжээнд Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа, тусгай зөвшөөрөлтэй, эмийн санд тавих нийтлэг шаардлага MNS 5262:2015 стандартыг хангаж шалгуурт тэнцсэн хувийн хэвшлийн 25 эмийн сан, сумдын 15 эргэлтийн эмийн сангуудтай “Даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх үйлчилгээг худалдан авах гэрээ”-г байгуулан ажиллаж хөнгөлөлттэй эм олгох журмын дагуу хяналт хэрэгжүүлэн олгож байна. Хөнгөлөлттэй эм олгосон санхүүжилтийг хүснэгтээр харуулбал: /Хүснэгт-10/

Эмийн сангуудад олгосон санхүүжилт 2021-2022 оноор													
№	Эмийн сан	2021 он						2022 он					
		Нэхэмжилсэн		Хасагдсан		Олгосон санхүүжилт		Нэхэмжилсэн		Хасагдсан		Олгосон санхүүжилт	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Эмийн сангуудаар	37165	1,052.70		3.2	37165	1049.5	48561	1,259.10	187	19	48374	1,240.10
2	Эргэлтийн эмийн сангуудаар	18965	421.4		0.107	18965	421.3	18212	436.7	116	11.8	18096	424.9
	Нийт дүн	56130	1,474.10	0	3.3	56130	1470.8	66773	1,695.8	303	30.8	66470	1,665.6

Хүснэгтээс харахад 2021, 2022 онуудад 122903 ширхэг эмийн хөнгөлөлттэй үйлчилгээ үзүүлж 3,169,9 сая төгрөгийн санхүүжилт нэхэмжилснээс ЭМДХ-ийн хяналтаар 34.1 сая төгрөгийн алдаатай гүйцэтгэл хасагдаж 3,136.4 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Аудитын явцад даатгалын гэрээний хэрэгжилт, санхүүжилтийн гүйцэтгэлд хяналтыг хэрэгжүүлэхэд дараах зөрчил дутагдал илэрлээ. Тухайлбал

- ✓ *Хос шүүдэргэнэ эмийн сан: эмийн санд тавих нийтлэг шаардлага MNS 5262:2015 стандартын шаардлагыг хангаагүй байхад тусгай зөвшөөрлийг сунгасан,*
- ✓ *Эмийн сангийн үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүд стандартын 11.10 зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад орсон, эмийн сангаар худалдахыг зөвшөөрсөн эмийн 90-ээс доошгүй хувийн нөөцтэй байна гэсэн заалтыг хангаадаагүй,*
- ✓ *Стандартын 11.4 эмийн жор бичилтэд тогтмол хяналт үнэлгээ хийж, зохистой жор бичилтийг төлөвшүүлэхэд харьяа нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагын эмнэлгийн мэргэжилтэнтэй хамтран ажиллана заалтыг хэрэгжүүлэн хүлээн авч буй жорд үнэлгээ хийж, эрүүл мэндийн байгууллагуудад танилцуулаагүй*

Өрхийн ЭМТ-ийн үйл ажиллагааны талаар:

Эрүүл мэндийн тухай хуульд “Өрхийн эрүүл мэндийн төв нь хот, суурин газрын хүн амд төрөөс үзүүлэх өрхийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх үндсэн чиг үүрэг бүхий сайн дурын үндсэн дээр бүртгүүлсэн хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага байна” гэж заасны дагуу Ховд аймагт нийт 6 өрхийн эрүүл мэндийн төв нөхөрлөл хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байна.

Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв нь ЭМДЕГ-тай гэрээ байгуулан иргэдэд анхан шатны тусламж үйлчилгээг дараах төрлүүдээр үзүүлж байна.

- ✓ *Сэргээн засах*
- ✓ *Гэрийн тусламж үйлчилгээ*
- ✓ *Оношилгоо шинжилгээ*
- ✓ *Өдрийн эмчилгээ*

Санхүүжилтийн эх үүсвэрийн хувьд:

Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаал, ЭМДҮЗ-ийн тогтоолуудыг үндэслэн эрсдэлийн коэффициент буюу тухайн эмнэлэгт хамаарах багийн иргэдийн тоог нэг иргэнд ногдох зардлын хэмжээгээр тооцон нийт төсвийг тодорхойлж байна.

Нийт төсвийн 80 хувийг сар бүрийн эхэнд эрүүл мэндийн байгууллагын үндсэн үйл ажиллагаанд зориулан Улсын төсвөөс, үлдсэн 20 хувийг олгохдоо гүйцэтгэлийг хянаж дараа сарын 20-ны дотор эрүүл мэндийн даатгалын сангаас олгохоор “Эмнэлгийн тусламж

үйлчилгээний тухай хууль” болон ЭМДҮЗ-ийн 2022 оны 05 дугаар тогтоолд тус тус заасан байна. Мөн байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, эрүүл мэндийн даатгалын сангаас зарцуулахыг хоригложээ.

Өрх, сум тосгоны эрүүл мэндийн төвийн хувьд 2021 онд дээрх зарчмаар санхүүжүүлж байсан бол 2022 оноос төр хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийг хянаж, олгохтой холбоотойгоор 100 хувь эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлсэн байна.

Өрхийн эрүүл мэндийн төвүүд нь хувийн хэвшлийн байгууллага байгаа нь дараах эрсдэлүүдийг бий болгож байна. Үүнд:

- ✓ Эрүүл мэндийн даатгалын сангаас олгож байгаа санхүүжилтийг эдийн засгийн ангиллаар хянах боломжгүй тул төсвийн сахилга алдагдах, төсвийг зориулалт бусаар зарцуулах
- ✓ Цалин хөлс, шагнал урамшууллыг засгийн газрын тогтоолд хязгаарлагдахгүй ялгаатай тогтоох
- ✓ Дотоод хяналт хэрэгжихгүй байх
- ✓ Ашиг сонирхол үүсэх
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллахгүй байх

ӨЭМТ-д хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ:

- ✓ ӨЭМТ-ийн байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд эрүүл мэндийн даатгалын сангаас 28.4 сая төгрөг зарцуулсан байна. Энэ нь Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт “Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх, хяналт тавих журам”-ын 3.5¹⁹ дахь заалтыг зөрчсөн бөгөөд Ховд аймгийн Засаг дарга, эрүүл мэндийн газартай байгуулсан гуравласан гэрээний дөрөвдүгээр зүйлийн 4.1 Аймгийн Засаг дарга нь дараах үүргийг хүлээнэ. 4.1.1²⁰, зургаадугаар зүйлийн 6.1 Төвийн дарга нь дараах үүргийг хүлээнэ. 6.1.15²¹ дахь заалтуудыг тус тус хэрэгжүүлээгүй байна
- ✓ ӨЭМТ-ийн дарга нар нь бүтэц орон тоо батлах, цалин тогтоох, шагнал урамшуулал олгох зэрэг шийдвэр гаргахдаа өөрөө өөртөө тушаал гарган байгууллагын төсвөөс зарцуулж байгаа нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1²² дэх заалттай нийцэхгүй байна.

БҮЛЭГ 2 Эрүүл мэндийн байгууллагаас даатгуулагчийн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцсэн зарим тусламж үйлчилгээг авч чадахгүй байна

¹⁹ “Сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон санхүүжилтийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд шилжүүлэхийг хориглоно”

²⁰ “Төвийг эмнэлгийн зориулалтын байраар хангаж, засвар үйлчилгээ, дулаан, цахилгаан, цэвэр усаар хангагдах нөхцөлийг бүрдүүлэн, тогтмол зардлыг хариуцан, төсвийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах”

²¹ “Төвийн үйл ажиллагааг хэвийн явуулах, үйлчлэх хүрээний хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, тулгамдсан асуудлаа холбогдох байгууллагад тухай бүр тавьж шийдвэрлүүлэх”

²² Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно

Эрүүл мэндийн даатгалын тогтолцоонд шилжсэнээр эрүүл мэндийн салбарт тодорхой ахиц дэвшил гарсан байна.

2.1 Даатгалд хамрагдаагүй иргэд өмнөх оноос буурсан үзүүлэлттэй ч өөрөө хариуцаж даатгалаа төлөх иргэдийн тоо буураагүй төр хариуцах иргэдийн тоо өссөн байна.

Эрүүл мэндийн даатгалын хуулийн 4-р зүйлийн 4.2²³-д зааснаар эрүүл мэндийн даатгалд 2020 онд 83648 иргэн, 2021 онд 86524 иргэн, 2022 онд 88471 иргэн хамрагдсан байна. Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан иргэдийн тоог хүснэгтээр харуулбал:

/Хүснэгт-11/

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛД ХАМРАГДАЛТЫН МЭДЭЭЛЭЛ /2020-2022 ОН/				
Үзүүлэлт	2020 он	2021 он	2022 он	Тайлбар авах
	тоо	тоо	тоо	
Шимтгэлийг ажил олгогч хариуцан төлөх иргэд	13,956	13,795.0	14,417	2020 он 798, 2021 он 4786, 2022 он 2190 хүнээр тус тус ЭМДЕГ-ын тоон мэдээлэлтэй зөрсөн
Төсөвт болон ААН байгууллагын ажилтан	13,956	13,795	14,417	
Шимтгэлийг өөрөө хариуцан төлөх иргэд	8,951	8,517.0	10,070	2020 онд 545, 2021 онд 3191, 2022 онд 4659 хүнээр тус тус ЭМДЕГ-ын тоон мэдээлэлтэй зөрсөн
Малчин	3,902	3,445	3,675	
Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн	3,533	3,974	5,759	
Их, дээд сургууль, коллеж, МСҮТ-ийн суралцагч	1,512	1,097	635	
Гадаадын иргэн, харьяалалгүй хүн	4	1	1	
Шимтгэлийг улсын төсвөөс хариуцах иргэд	60,741	64,212.0	63,984	өссөн
0-18 насны хүүхэд	32,584	35,097	36,087	
Тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй иргэн	13,545	14,250	15,542	өссөн
Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн	10,576	12,193	9,143	
Хүүхдээ асарч буй эх/эцэг	3,317	2,124	2,766	
Хугацаат цэргийн жинхэнэ албан хаагч	717	422	322	
Ял эдэлж байгаа ялтан	2	126	124	
Бусад /хуулийн 6.1.12 дахь заалтын даатгуулагч/	-	-	-	
Хамрагдсан хүний тоо	83,648	86,524.0	88,471	
Аймгийн нийт хүн амын тоо	88,974	90,333.0	90,671	

²³ Монгол улсын иргэн эрүүл мэндийн улмаас учирч болзошгүй санхүүгийн эрсдэлээ хуваалцах зорилгоор эрүүл мэндийн албан журмын даатгалд заавал даатгуулна

Хамрагдаагүй хүний тоо	5,326	3,809.0	2,200
------------------------	-------	---------	-------

Дээрх хүснэгтээс харахад 2020 онд 5326, 2021 онд 3809 иргэн болж өмнөх оноос 1517 иргэн, 2022 онд 2200 иргэн болж өмнөх оноос 1609 иргэнээр буурсан байгаа нь сайн үзүүлэлт боловч буурч байгаа шалтгаанд нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн төрөл дотор байгаа “амьжиргаа төр хариуцах” ангилалд багтсан иргэдийн тоо нь өөрөө хариуцан төлөх иргэдийн тоог бууруулж байна. Төр хариуцах иргэдийн амьжиргааны түвшин тогтоож байгаа шалгуур үзүүлэлт үндэслэл муутай байна.

2.2 Цахим мэдээллийн системийн хөгжүүлэлтийг сайжруулах шаардлагатай, иргэдийг шаардлагатай мэдээллээр хангах, чанартай тусламж, үйлчилгээг үзүүлэх нөхцөл бүрэн бүрдээгүй байна.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 11.2²⁴-д зааснаар Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2021 оны 1 дүгээр сарын 21-ний өдрийн 03 дугаар тогтоолоор “Тусламж үйлчилгээний санхүүжилтийн шинэчилсэн жагсаалт, журам” батлагдаж тогтоол хэрэгжиж эхэлснээр эрүүл мэндийн салбарт хэд хэдэн шинэчлэл эхэлсэн байна. Үүнд:

- ✓ Өндөр өртөгтэй хагалгааны зардлыг иргэнээс гаргуулах бус Эрүүл мэндийн даатгалын сангаас шийддэг болж аймгийн хэмжээнд 2021 онд 123.3 сая, 2022 онд 338.1 сая төгрөгийн санхүүжилт олгосон,
- ✓ Хорт хавдар, харвалт, шигдээс, түлэгдэлт, төрөлхийн гажиг, төрөх, эмэгтэйчүүд, халдварт өвчин гэх мэт амь нас аврах нэн шаардлагатай эрүүл мэндийн үйлчилгээг 100 хувь ЭМД-ын сангаас санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн,
- ✓ Эмч мэргэжилтнүүд олон улсын эмнэл зүйн удирдамжийн UpToDate цахим платформыг үнэгүй ашиглах боломжийг бүрдүүлснээр эмчилгээ оношилгоог олон улстай хөл нийлүүлэн, нотолгоонд суурилан хийх боломж бүрдсэн,
- ✓ Гүйцэтгэлд суурилсан эрүүл мэндийн даатгалын тогтолцоонд шилжсэнээр эмнэлгийн ажилчдын нийгмийн баталгаа хангагдаж цалин, урамшуулал, нэмэгдэх боломж бүрдсэн байна.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд зарцуулдаг, өөрөөр хэлбэл, төрөөс төлбөрийг нь хариуцдаг тусламж, үйлчилгээний зардлыг улсын төсвөөс даатгалын сан руу нэгтгэж нэг эх үүсвэрээс эрүүл мэндийн бүхий л тусламж, үйлчилгээг санхүүжүүлдэг болсноор эмнэлгүүдийг орцод суурилан зардлын зүйл ангиар санхүүжүүлдэг байсныг бүрэн халж, гарцад буюу эмнэлгүүдийн үзүүлсэн тусламж, үйлчилгээгээр нь чанарын хяналт хийж байж гүйцэтгэлээр санхүүжүүлдэг болсон ч зарим тусламж үйлчилгээг орон нутгийн иргэд бүрэн авч чадахгүй байна. Тухайлбал:

- Аймгийн хэмжээнд хорт хавдартай 206, даралт харвасан давхардсан тоогоор 792 өвчтөн эмчийн хяналтад байж хөнгөвчлөх, сэргээн засах эмчилгээ хийлгэж байгаа боловч мэргэжлийн эмч байхгүй шалтгаанаар эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт авах гэрээ хийгээгүйгээс байгууллага эмчилгээ үйлчилгээ үзүүлсэн зардлаа авч чадаагүй байна. ЭМД-ын тухай хуулийн 3-р зүйлийн 3.1.7²⁵-д заасан

²⁴ Энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын эрүүл мэндийн даатгалын сангаас болон даатгуулагчаас төлөх төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журмыг эрүүл мэндийн даатгалын байгууллага болон санхүү, төсвийн, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг тус тус үндэслэн Үндэсний зөвлөл тогтооно.

²⁵ Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц” гэж даатгуулагчид үзүүлэх зайлшгүй хэрэгцээтэй оношлох, эрт илрүүлэх, эмчлэх, ХОА-2023/19/ШТА-ГА/

үйлчилгээг бүрэн авч чадахгүй байгаагаас нэг иргэн 5-6 удаа хот руу явж эмчилгээ, сувилгаанд орж эдийн засгийн болон сэтгэл санаагаар хохирч байна.

- Ховд аймагт орчны бохирдол, хүнсний аюулгүй байдал, зохисгүй хэрэглээ, хөдөлгөөний дутагдлаас үүдэлтэй сахрын өвчлөл 2020 онд 598, 2021 онд 640, 2022 онд 692 болж нэмэгдсэн, нас баралт 26 тохиолдол болж анхаарал хандуулах түвшинд хүрчээ. Төлбөрийг нь төр хариуцах дан найрлагатай эмүүд цусан дах сахрын хэмжээг буулгах үйлдэл сул байгаа учир хүндрэл үүсэх эрсдэл өндөр байгаа тул нийлмэл найрлагатай эм болох Глизид м, Галбус мед 1000/50 мг-тайг, сэтгэцэд нөлөөт эмийн ангилалд Трамдол 2 мг, Трамдол 50мг капсулаар нэмэлтээр оруулах шаардлагатай байна.
- ЭМД-ын ҮЗ-ийн 2021 оны 3-р тогтоолын 2.2²⁶-д заасны дагуу өндөр өртөгтэй компьютер томограф, MRI зэрэг оношилгоо, зарим мэс заслын төлбөр зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх хууль эрх зүйн орчин бүрдсэн ч аймгийн хэмжээнд MRI аппарат, тоног төхөөрөмж дутмагаас яаралтай тохиолдолд энэ боломжийг иргэд эдэлж чадахгүй байна. Улаанбаатар хот руу 2021 онд 1841, 2022 онд 3781 өвчтөн оношилгоо шинжилгээ хийлгэхээр явсан бөгөөд хугацаа алдах нөхцөл үүсэж амь насны болон санхүүгийн хүндрэл бэрхшээл тулгарч байна.
- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц нь орон нутгийн даатгуулагчийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн тусламж, үйлчилгээг бүрэн хамардаггүй тул нэр заасан тусламж, үйлчилгээнд нь багтаагүй тохиолдолд даатгуулагч үйлчилгээ авах нөхцөл бүрдэхгүй байна. Тухайлбал: ЭМДЕГ-тай гэрээлж чадаагүй тусламж, үйлчилгээг хүснэгтээр харуулбал: /Хүснэгт-12/

ЭМД-аас тусламж үйлчилгээ авч чадахгүй байгаа үйлчилгээний төрөл
1. 310011-Яаралтай тусламж, үйлчилгээ - Улаан
2. 310018-Яаралтай тусламж, үйлчилгээ - Шар /А
3. 310019-Яаралтай тусламж, үйлчилгээ - Ногоон /А
4. 310015-Гэмтлийн яаралтай тусламж, үйлчилгээ - Улаан
5. 240011-Эрчимт эмчилгээ А
6. 320021-Телемедицин
7. 350012-Ахмадын сэргээн засах хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ
8. 350013-Гэмтэл, согогийн сэргээн засах хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ
350016-Үе мөч, тулгуур эрхтний сэргээн засах хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж, улсын эмнэлгүүдийн ачаалал, даатгалаар үйлчилдэг хувийн эмнэлгүүдийн дараалал ихээс шалтгаалан хэрэгцээт үйлчилгээг авч чадахгүй, даатгалаар үйлчилдэггүй хувийн эмнэлгүүдээс төлбөртэй үйлчилгээ авах сонголттой тулгарч байна.

2.3 Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаар даатгуулагчид мэдээлэл өгсөн байна.

Даатгуулагчийн эрх болон эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах боломжийн талаарх мэдээ, мэдээллийг зурагт постер, хөдөлгөөнт постер, лайв, видео хэлбэрээр олон

сэргээн засах, асрах, сувилах, хөнгөвчлөх болон эмийн үнийн хөнгөлөлтийг багтаасан эрүүл мэндийн цогц тусламж, үйлчилгээг;

²⁶ Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга шинэчлэн батлах журмын 4-р хавсралт

нийтэд хүргэсэн байна.

Эрүүл мэндийн даатгалын хууль тогтоомж тогтоолуудын өөрчлөлтүүдийг иргэд, олон нийтэд хүргэх зорилгоор “ХОВД АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС” пэйж хуудсыг нээн ажиллуулж байна. Пэйж хуудасны хандалтыг тоог 3200 гишүүнээр нэмэгдүүлж 3798 дагагчидтай болгосон. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын пэйж хуудсанд тавигдсан 59 мэдээ мэдээллүүдийг хэлтсийн пэйж хуудсанд байршуулж 20073 иргэн даатгуулагчд түгээж ажилласан. Өөрсдөө 15 контент, мэдээллүүдийг бэлтгэж пэйж хуудсанд байршуулан 17560 иргэн даатгуулагчдад хүргэсэн мөн Ховд телевизтэй хамтран ажиллах гэрээ байгуулж 10 удаагийн телевизийн нэвтрүүлэг хийж иргэн даатгуулагчид мэдээлэл хүргэсэн байна.

Аман болон утсаар иргэд өөрөөс төлж байгаа эмчилгээ үйлчилгээний төлбөрийн талаар гомдол мэдээлэл өгдөг ч нотлох баримт байхгүйгээс шийдвэрлэгдсэн асуудал байхгүй байна.

Эрүүл мэндийн даатгалын салбарын хяналт шалгалт, дотоод аудитын үйл ажиллагаа бүрэн хэрэгжихгүй байна.

3.1 Бодлогын баримт бичигт тусгасан зорилт, арга хэмжээний хэрэгжилт хангалттай хэрэгжсэн байна.

Эрүүл мэндийн даатгалын шинэчлэлийн хүрээнд Улсын Их Хурлын 2020 оны 8 дугаар сарын 28-нд Эрүүл мэндийн тухай, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр нэг худалдан авагчийн тогтолцоо бий болох, стратегийн худалдан авалтыг хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчин бүрдсэн байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний багцуудыг тодорхойлох, төлбөрийн арга, өртөг тарифыг шинэчлэх, эрүүл мэндийн байгууллагыг сонгон шалгаруулах журам, шалгуурыг боловсруулах, тусламж, үйлчилгээний чанарын хяналтын журам, шалгуурыг оновчтой болгох ажил эрчимтэй явагдаж холбогдох тогтоол, шийдвэрүүд батлагдан гарсан байна. Салбарын хэмжээнд хэрэгжиж буй томоохон хөрөнгө оруулалтыг дурдвал:

- ✓ Улсын төсвийн хөрөнгөөр 5100.0 тэрбум төгрөгийн өртөг бүхий 50 ортой хүүхдийн эмнэлгийг 2021 онд ашиглалтад оруулсан
- ✓ Булган өрхийн эмнэлгийн барилгыг 1.2 тэрбум төгрөгийн хандиваар барьсан, нийгмийн оролцооны дэмжлэгээр, улсын төсвийн хөрөнгөөр 4800.0 тэрбум төгрөгийн өртөг бүхий Дөргөн сумын эмнэлгийн барилга, Буянт өрхийн эмнэлгийн барилга баригдаж байгаа
- ✓ Улсын төсвийн хөрөнгөөр Алтай, Өвсний үндэс төсөл хөтөлбөрөөр Мөнххайрхан сумын эмнэлгийн өргөтгөл 70 хувьтай, Мянгад сумын барилгын ажил 50 хувьтай, Дарви сумын эмнэлгийн засвар 50 хувьтай тус тус хийгдэж байна.
- ✓ Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамгийн сүүлийн үеийн технологийн шинэчлэлтэй программ хангамж бүхий олон үйлдэлтэй “Ангиографийн оношилгоо”-ны тоног төхөөрөмж, 115 ширхэг стандартын ор, суурин Эхо аппаратууд, нярайн амьсгалын аппарат, жирэмсэн эмэгтэйн эрүүл мэндийн байдлаас ургийн хөгжилд эмгэг үүсгэх эмгэгээс урьдчилан сэргийлэх ургийн СТГ аппарат, доплерийн хэт авиан шинжилгээний аппарат зэрэг 58 нэр төрлийн 2.3 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмжийг олгож, Булган суманд сүүлийн үеийн рентген аппаратыг суурилуулсан байна

3.2 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар болон төлбөрийн нэхэмжлэлийн

бодит гүйцэтгэлд хяналт хэрэгжүүлж чадахгүй байна.

ЭМДЕГ-аас 2022 онд Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 10-р зүйлийн 10.1²⁷, 16.1.3²⁸, Засгийн газрын 2015 оны 485 дугаар тогтоолын 5.1.1²⁹, 6.3.1 дэх заалтыг үндэслэн ЭМДЕГ-ын эмнэл зүйн аудит хийх шинжээчийн ажлын удирдамжийн дагуу БОЭТ-ийн тусламж үйлчилгээ худалдан авах гэрээний үүргийн биелэлтэд хяналт хэрэгжүүлж 113.7 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосон байна. Актаар тогтоосон зөрчлийн товч утгыг харуулбал:

- ✓ Өндөр өртөгтэй оношилгоо шинжилгээ 660.0 мянган төгрөг
- ✓ Элэгний фиброз ба цирроз 13.5 сая төгрөг
- ✓ Яаралтай тусламж үйлчилгээ улаан эрэмбэ 99.5 сая төгрөг

Аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь хүний нөөц дутагдалтай байгаагийн улмаас нэг хүнд ноогдох ажлын ачаалал их, бичиг хэрэг, сургалт, мэдээлэл, газар дээрх хяналт үнэлгээ, гэрээ дүгнэх, цахим хяналт хийж хэрэгжүүлэхэд хүрэлцээгүй байдаг тул иргэдэд сургалт мэдээлэл өгөх, газар дээрх хяналт үнэлгээ хийж хүрч үйлчилж чаддаггүй байна.

3.3 Эрүүл мэндийн байгууллагуудад Эрүүл мэндийн газрын хяналт шинжилгээ үнэлгээний хэлтсээс хяналт хэрэгжүүлж ажилласан байна.

Ховд аймгийн ЗДТГ-аас ЭМГ-т эрүүл мэндийн салбарын үйл ажиллагааг үнэлэх шалгалтын ажлын хэсэг ирж Хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын үндсэн чиг үүрэг, байгууллагын дотоод ажил, санхүү төсвийн үйл ажиллагаа, ил тод нээлттэй байдалд хяналт үнэлгээ хийж 98%-тай дүгнэсэн байна.

ЭМГ-аас 2022 оны хяналт шинжилгээ үнэлгээний график төлөвлөгөөний дагуу ажлын хэсэг байгуулан удирдамжийн дагуу 2021 онд хувийн хэвшлийн 18 байгууллага, цэргийн ангийн 0123 дугаар ангийн эмнэлэг, Үенч суман дахь цэргийн ангийн 0130 дугаар анги, 6 өрхийн эрүүл мэндийн төвүүд, 16 сумын ЭМТ, 16 Эмийн сан, 5 эм ханган нийлүүлэх байгууллага, ЗООНОЗ, БОЭТ, дэмжлэгт хяналт шинжилгээ үнэлгээг хийсэн байна. 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт 67 байгууллагад хяналт шинжилгээ үнэлгээ хийж, эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж, зөвлөн тусалж, Эрүүл мэндийн сайдын А/343 дугаар шинэчилсэн тушаалаар сургалт зохион байгуулж, дэмжлэгт хяналт шинжилгээ үнэлгээ хийсэн ба байгууллага тус бүрээр дараах зөвлөмжийг хугацаатай хүргүүлсэн байна. Тухайлбал:

- ✓ Эмийн эмчилгээг зохицуулах хорооны дэргэдэх антибиотикийн дэд хорооны үйл ажиллагаа, ажлын төлөвлөгөөний биелэлтийг хянаж, эмийн эмчилгээг зохицуулах хороогоор хэлэлцүүлдэг байх,
- ✓ ЭМС-ын 2017 оны 505 тоот тушаалын 1.3.4 дэх заалт эмийн гаралтай хог хаягдал /хугацаа дууссан, хагарч гэмтсэн, сав баглаа боодол гэмтсэн зэрэг/ үүссэн тохиолдолд үйлдвэрлэгч, ханган нийлүүлэгч, хандивлагч байгууллагад буцаалт хийнэ заалтын хэрэгжилтийг хангах, эмийн гаралтай хог хаягдлын устгалын бүртгэлийг хөтөлж хэвших,
- ✓ Эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж оношлуур худалдан авсан байгууллагуудын үйл

²⁷ "ЭМД-ын байгууллага энэ хуулийн 16.1.4-т заасны дагуу сонгон шалгаруулалтад тэнцсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага болон эмийн сантай даатгалын гэрээ байгуулах бөгөөд гэрээний хэрэгжилтийг хянаж дүгнэнэ",

²⁸ Даатгуулагчийг төлөөлж Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч байгууллагатай тусламж үйлчилгээ худалдан авах, даатгалын гэрээ байгуулах, гэрээний биелэлтэд хяналт тавих, дүгнэх

²⁹ Дотоод аудитын дүрэм журам

ажиллагааны чиглэлийг гэрчлэх баримт, тусгай зөвшөөрөл гүйлгээнд хавсаргаж байх. Тусгай зөвшөөрөлгүй байгууллагуудаас худалдан авалт хийхгүй байх,

- ✓ Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулах болон эрсдэлийн төлөвлөгөөгөө батлуулах, төлөвлөгөөний биелэлтийг хагас, бүтэн жилээр тооцож тайлагнах,

Эрүүл мэндийн сайдын 2017 оны 505 тоот тушаалын 1.3.4 дэх заалтын дагуу хугацаа дууссан эмийн гаралтай хог хаягдлыг татан авалт хийсэн ханган нийлүүлэх байгууллагадаа буцаалт хийх тухай заасан байдаг. Гэвч татан авалт хийсэн эм ханган нийлүүлэх байгууллага нь хугацаа дууссан эмийг хүлээн авахгүй байх, эмийн устгалыг журмын дагуу хийхээс татгалзаж байгаа тухай эмнэлэг, эмийн сангуудаас гомдол ихээр ирүүлсэн. Үүнтэй холбогдуулан улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй эм ханган нийлүүлэх байгууллагуудыг тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллах чиглэл өгөхийг хүсэн холбогдох албан бичгийг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газарт хүргүүлсэн байна.

БОЭТ-д дэмжлэгт хяналт үнэлгээ хийх график хуваарийн дагуу Хүлээн авах, яаралтай тусламжийн тасаг, Гемодиализийн тасаг, Эм зүйн албаны үйл ажиллагаатай танилцан Эмийн санд тавигдах нийтлэг шаардлага MNS 5260:2015, Эмийн жорын маягт, жор бичилт MNS 5376:2016, ЭМС-ын 2019 оны 294, ЭМС-ын 2013 оны 415 тоот тушаал болон бусад холбогдох эрх зүйн актуудын хэрэгжилтийг үнэлэн, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, зөвлөмж хүргүүлсэн байна.

3.4 Эрүүл мэндийн даатгалын байгууллага цаг үеийн мэдээллийг пэйж хуудсаараа мэдээлсэн байна.

ЭМБ-аас даатгуулагч-иргэний нэр дээр ирсэн гүйцэтгэлийн нэхэмжлэлийн мэдээллийг манай байгууллагын +133103 дугаараас тухайн иргэний утсанд мессежээр илгээж тусламж, үйлчилгээ авсан эсэх болон тусламж, үйлчилгээнийхээ чанарын талаар санал хүсэлтээ илгээх боломжтой болсон байна. Ингэснээр гүйцэтгэлийн нэхэмжлэлийн хяналтыг сайжруулах, иргэн-даатгуулагч өөрийн авсан тусламж, үйлчилгээний санхүүжилтийн мэдээллээ давхар хянах, эрүүл мэндийн байгууллагууд даатгалын сангаас авч байгаа санхүүжилтийг даатгуулагч-иргэд мэдэх боломжтой байна.

Аудитаар нийт 7252.8 сая төгрөгийн зөрчил илэрснээс 5866.2 сая төгрөгийн 4 албан шаардлага, 1386.3 сая төгрөгийн 16 зөвлөмжийг өглөө.

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

- **Хөгжлийн бодлогын баримт бичигт эрүүл мэндийн даатгалын талаар тусгасан зорилтын хэрэгжилт хангагдсан байна.**
- **Эрүүл мэндийн байгууллагаас даатгуулагчийн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцсэн зарим тусламж үйлчилгээг авч чадахгүй байна**

ҮАГ-ын нэгдсэн тайланд улсын хэмжээнд анхаарч тусгуулах санал:

1.ӨЭМТ-н үйл ажиллагаа нь Монгол Улсын хууль “Нөхөрлөлийн тухай хууль”-иар зохицуулагдан үйл ажиллагаа явуулж байна.

Өрхийн эрүүл мэндийн төвийн өмчийн хэлбэрийг өөрчилж төсвийн байгууллага болговол

улсын болон орон нутгийн төсөв, эрүүл мэндийн даатгалын сангаас олгож байгаа санхүүжилтийг бүрэн хянаж, зардлыг багасгах боломжтой байна. Шалтгаан нь :

- *Өрхийн ЭМТ-ийн хөрөнгө орон нутгийн өмчид бүртгэлтэй, хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээнд улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт болон хөрөнгө оруулалт хэрэгждэг*
- *Өрхийн ЭМТ-ийн тогтмол зардлыг орон нутгийн төсвөөс олгож байгаа*
- *ӨЭМТ-ийн дунд 3 нягтлан бодогч стандартын дагуу ажиллаж байгаа хэдий ч Эдийн засгийн ангиллаар хуваарилаагүй 2.8 тэрбум төгрөгийн төсвийг төрийн ямар нэгэн хяналтгүйгээр арилжааны банкаар дамжуулан зарцуулсан*

2.Чанар, үйлчилгээний төлбөрийн нэхэмжлэлд хяналт хэрэгжүүлж хасагдал хийж байгаа зарим үзүүлэлт ЭМС-ын 2016 оны 611-р тушаалаар батлагдсан анхан шатны бүртгэл хөтлөлтийн маягт e-Health программд бүрэн ороогүй, тогтоол шийдвэр байнга солигддог мэдээлэл дутмаг байгаад ЭМДЕГ-т программ хөгжүүлэлтийг сайжруулах орон нутгийн ЭМБ-ыг мэдээллээр хангах зөвлөмж оруулах

3.Аймгийн хэмжээнд 90651 хүн аж төрж амьдарч байна. БОЭТ-д үзүүлж буй нийт тусламж үйлчилгээний 10 хувийг харьяа бүсийн аймгуудын хүн амд үзүүлсэн байна. Оношилгоо шинжилгээ хийлгэхээр жилд дунджаар 3281 хүн Улаанбаатар хот руу явж байна. Бүс нутгийн хэмжээнд жил бүр хүн амын тоо өссөнтэй холбоотой өндөр төлбөртэй оношилгоо шинжилгээ хийлгэх MRI аппарат нэн шаардлагатай байна. Байгууллага өөрөө худалдан авах санхүүгийн эх үүсвэр хомс тул улсын төсөв болон орон нутгийн төсвөөс шийдвэрлүүлэх талаар санал оруулах

4.Ховд аймагт орчны бохирдол, хүнсний аюулгүй байдал, зохисгүй хэрэглээ, хөдөлгөөний дутагдлаас үүдэлтэй сахрын өвчлөл 2020 онд 598, 2021 онд 640, 2022 онд 692 болж нэмэгдсэн, нас баралт 26 тохиолдол болж анхаарал хандуулах түвшинд хүрчээ. Төлбөрийг нь төр хариуцаж байгаа дан найрлагатай эмүүд цусан дах сахрын хэмжээг буулгах үйлдэл сул байгаа учир хүндрэл үүсэх эрсдэл өндөр байгаа тул нийлмэл найрлагатай эм болох Глизид м, Галбус мед 1000/50 мг-тайг, сэтгэцэд нөлөөт эмийн ангилалд Трамдол 2 мг, Трамдол 50мг капсулаар нэмж оруулах зөвлөмж өгөх

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөмж болгож байна. Үүнд:

ЭМГ-ын дарга Б.Мягмарсүрэн-д

- 1.Эмийн сангуудын MNS 5262:2015 стандартын шаардлагыг хангаагүй байхад тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахгүй байх.
- 2.Эмч эмнэлгийн ажилчид өөрийн болон бусад хувийн эмнэлгүүдэд давхар ажиллаж байгаа нь иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар муудах, дараалал хүлээгдэл үүсэх эрсдэлтэй байгаад хяналт хэрэгжүүлж таслан зогсоох

ӨЭМТ-ийн дарга нягтлан бодогч нарт

1. Тус өрхийн ЭМТ-ийн дарга нь бүтэц орон тоо батлах, цалин тогтоох, шагнал урамшуулал олгох зэрэг шийдвэр гаргахдаа өөрөө өөртөө тушаал гарган

байгууллагын төсвөөс зарцуулахгүй байх, харьяа дээд шатны удирдлагаар гүйцэтгэлийн гэрээг дүгнүүлэн тушаал шийдвэр гаргуулж хэвших.

2. Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа хөрөнгийн бүртгэл санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудитыг хяналтыг хэрэгжүүлж ажиллах

Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн дарга Ч.Уранчимэг-т

1. Аймгийн хэмжээний Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого болон эрүүл мэндийн байгууллагуудад олгосон тусламж үйлчилгээний санхүүжилтийн талаарх суурь мэдээллийн баазтай байх
2. ЭМБ-аас ирж байгаа чанар, төлбөрийн хяналтын шалгуур үзүүлэлт, амьдрал дээр гарч буй эрсдэл, санхүүжилтийн талаарх саналаа дээд байгууллагадаа хүргүүлж байх
3. Чанар, төлбөрийн хяналт хийсэн нэхэмжлэлийн хяналтын тайланг гаргах, дүн шинжилгээ хийх, нэхэмжлэлийн хяналтаар хасагдсан тохиолдол тус бүрээр хавсралтад заасан загварын дагуу дэлгэрэнгүй тайланг сар бүр гаргаж ЭМБ-д хүргүүлэх, зөвлөмж өгөх
4. Хувийн хэвшлийн эмнэлгүүд даатгалаас санхүүжилт авахын тулд төрийн байгууллагын эмч,ажилчдын бичиг баримт ашиглах магадлалтай байгааг анхаарч сонгон шалгаруулалтын хяналтыг сайжруулах, зохих шатанд мэдээлэх
5. Эрүүл мэндийн даатгалд хамрагдахгүй байгаа иргэдэд даатгалын ач холбогдлыг сурталчлах, даатгалын төлбөр үйлчилгээний талаарх мэдээллийг ил тод хүртээмжтэй хүргэж сургалт, сурталчилгааг нэмэгдүүлэх

БОЭТ -ийн захирал Д.Баяртогтох-д:

1. ТУЗ-ийг нэн даруй байгуулах талаар холбогдох газарт саналаа хүргүүлэх, хүний нөөцийн оновчтой бодлого баримтлах, шаардлагатай хөрөнгө оруулалтын ажлуудын судалгааг гарган бизнес төлөвлөгөөнд тусгаж эх үүсвэрийг батлан хэрэгжүүлэх,
2. Иргэдийн өсөн нэмэгдэх эрэлт хэрэгцээг хангах тусламж үйлчилгээний нөхцөлийг бүрдүүлэх, эдийн засгийн үр ашгийг тооцож санхүүгийн эрсдэлийн төлөвлөгөө гарган батлуулж үр ашигтай чанартай үйлчилгээнд суурилсан хэмнэлтийн горимд шилжих
3. Эдийн засагч, даатгал хариуцсан ажилчдын ур чадварыг дээшлүүлэх, эмч, эдийн засагч нарын ажлын хариуцлагыг нэмэгдүүлж шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах,
4. Аймгийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш нарыг эрүүл мэндийн нэмэлт үзлэг, оношилгоонд хамруулахдаа мэдээллийг ЭМЯ-ны мэдээллийн санд бүртгэж мэдээллийн бааз бүрдүүлэх, ерөнхий мэдээллийг баталгаажуулан Төсвийн шууд захирагчид хүргүүлэх
5. Хувийн эмнэлэгтэй болон хувийн эмнэлэгт давхар ажиллаж байгаа эмч, ажилчдын иргэдэд үзүүлж байгаа чанар үйлчилгээ буурах, хүлээгдэл үүсэх нөхцөл бүрдэж байгааг анхаарах
6. Тендерийн гэрээгээр эм, эмийн хэрэгсэл нийлүүлж байгаа аж ахуйн нэгж байгууллагуудтай гэрээний үр дүнг тооцох, шууд худалдан авалтын гэрээг бууруулах, цахим худалдан авалтын бодлого баримтлах

Баатархайрхан ӨЭТ-ийн дарга Ц.Отгонзаяа-д

1. Гранд старекс ХХК-наас нийлүүлэгдсэн автомашины холбогдох бичиг баримтыг бүрдүүлэн данс бүртгэлд тусгах

Аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэн ажиллах, ажлын төлөвлөгөө гарган, биелэлтийг тооцон 2023 оны 11 дугаар сарын 25-ны дотор ирүүлэхийг дээрх албан тушаалтнуудад өглөө.

Алдаа зөрчлийн нэгтгэл

№	Алдаа зөрчлийн утга	Нийт алдаа, зөрчил /сая. Төгрөг/		Үүнээс			
				Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3		4		6
1	Аймгийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш нарыг эрүүл мэндийн нэмэлт үзлэг, оношлогоонд хамруулахдаа мэдээллийг ЭМЯ-ны мэдээллийн санд бүртгээгүй, Эрүүл мэндийн нэмэлт үзлэг, оношлогоонд хамрагдсан багш нарын эрүүл мэндийн үзлэг, оношлогооны ерөнхий мэдээллийг баталгаажуулан зөвлөмжийн хамт Төсвийн шууд захирагчид хүргүүлээгүй	1	-			1	-
2	Гэмт хэрэг, зөрчлийн улмаас эрүүл мэнд нь хохирсон даатгуулагчийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардлын төлбөрийг ЭМД-ын сангаас олгосон, түүнийг буруутай этгээдээр төлүүлэх талаар арга хэмжээ аваагүй	1	11.8	1	11.8		
3	ЭМДХ-ээс чанар, төлбөрийн хяналт хийж нэхэмжлэлд хасалт хийгдсэн шалтгаанд дүн шинжилгээ хийгээгүй, хасагдлыг бууруулах талаар бодитой ажил зохион байгуулаагүй, өндөр дүнтэй хасагдал хийгдэж байгаа нь эмчилгээ, үйлчилгээний чанарт нөлөөлөх эрсдэл үүссэн	1	5,792.1	1	5,792.1		
4	БОЭТ нь 2022 оны 3 дугаар сард ЭМДЕГ-тай байгуулсан гэрээнд үзүүлэх тусламж үйлчилгээний нэр төрөлийг тоо хэмжээгээр зааж өгсөнөөс илүү нэхэмжилсэн мөн эрүүл мэндийн даатгал төлөөгүй иргэдийн тусламж авсан төлбөрийг авч чадаагүйгээс байгууллага хохирох нөхцөл бүрдсэн	1	-			1	
5	Аймгийн эрүүл мэндийн даатгалын байгууллага нь аймгийн хэмжээний статистик тоон мэдээлэлгүй, эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, эрүүл мэндийн байгууллагуудад олгосон тусламж үйлчилгээний санхүүжилтийн талаарх судалгаа мэдээлэл хангалтгүй,	5	-			5	
6	Тендерийн гэрээ байгуулсан аж ахуйн нэгжүүдийн эрээний хэрэгжилт хангалтгүй 73.7 хувьтай хэрэгжиж шууд гэрээгээр худалдан авалт хийсэн	4	1,354.6			4	1,354.6
7	ӨЭМТ-ийн байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 28.4 сая төгрөг зарцуулсан байна.	1	28.4	1	28.4		
8	ЭМТ-ийн дарга нь бүтэц орон тоо батлах, цалин тогтоох, шагнал урамшуулал олгох зэрэг шийдвэр	1	-			1	

	гаргахдаа өөрөө өөртөө тушаал гарган байгууллагын төсвөөс зарцуулсан						
9	Хос шүүдэргэнэ эмийн сан нь эмийн санд тавих нийтлэг шаардлага MNS 5262:2015 стандартын шаардлагыг хангаагүй байхад тусгай зөвшөөрлийг сунгасан, Эмийн сангийн үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүд нөөц бүрдүүлэлт хангалтгүй, хүлээн авч буй жорд үнэлгээ хийж, эрүүл мэндийн байгууллагуудад танилцуулаагүй	1	-			1	
10	Ач заяа, Мөнх цохилохуй, Мөнгөн морьт эмнэлгүүд иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ, төлбөрийн хэмжээний хавсралтад амбулаторийн үйлчилгээ үзүүлэхэд иргэдээс төлбөр хураамж авахгүй гэсэн байгаа боловч газар дээр хяналтыг хэрэгжүүлэхэд 20000 - 23000 төгрөгийн төлбөр авсан зөрчил илэрлээ	1	33.9	1	33.9		
11	Баатархайрхан өрхийн ЭМТ-д ЗГХЭГ/202102037-01 тоот гэрээ хийгдэж түргэн тусламжийн Гранд старекс авто машин нийлүүлэгдсэн ч тухайн байгууллагын үндсэн хөрөнгөд данс бүртгэлд тусгаагүй байна. Тухайн авто машины Монгол улсын хилээр орж ирсэн гаалийн бичиг баримтын бүрдэл дутуу байхад хүлээн авах акт үйлдэгдсэн байна.	3	32.0			3	32.0
	ДҮН	20	7,252.8	4	5,866.2	16	1,386.6

ХОВД АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР